

ХАРИЛЦАА ХОЛБООГ

МӨРДӨН ТАГНАХ

АЖИЛЛАГААНД

ХҮНИЙ ЭРХИЙН

ОЛОН УЛСЫН ЗАРЧМЫГ

БАРИМТЛАХ ТАЛААРХ

БҮХ НИЙТЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ

УДИРДАМЖ

 ACCESS БАЙГУУЛАГААС ЭРХЛЭН ГАРГАВ

accessnow.org



АГУУЛГА

Зарчмуудын товч тайлбар.....	04
Оршил	06
Танилцуулга	06
Хувийн нууц болон мөрдөн тагнах ажиллагааны хууль зүйн.....	06
Зарчмуудын хандлага.....	05
Удирдамжид ашигласан нэр томъёо.....	09
Мэдээлэл авах талаарх Засгийн газрын өргөдөл.....	11
Өргөдөл гаргах эрх мэдэлтэн.....	11
Хайлт хийх хэрэгцээ шаардлага.....	12
Өргөдлийн хэлбэр.....	13
Өргөдлийн агуулга.....	14
Нотлох үүрэг.....	15
Онцгой ажиллагааны журам.....	16
Шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа.....	18
Шүүн таслах эрх бүхий байгууллага.....	18
Өргөдлийн үндэслэл бүхий байдал.....	19
Нотлох баримтын стандарт.....	20
Шүүхийн шийдвэрийн агуулга хэлбэр.....	21
Шүүхийн хяналт.....	22
Мөрдөн шалгах ажиллагаа.....	23
Онцгой ажиллагааны журам.....	24
Хайлт хийх	27
Хайлтын хамрах хүрээ	27
Зардал	27
Хайлт хийх тухай хүсэлт гаргах	28
Хэрэглэгчид мэдэгдэх	29
Үйлчилгээ үзүүлэгчийн хариу үйлдэл ба асуудал бэрхшээл.....	30

Өгөгдлийн засаглал	32
Үйлчилгээ үзүүлэгчийн ил тод байдал	33
Давж заалдах гомдол гаргах ба эрх зүйн хамгаалалт.....	36
Хууль бус хандалтын эсрэг шийтгэл	36
Хууль бусаар олж авсан мэдээллийг хүлээн зөвшөөрөх	37
Засгийн газрын ил тод байдал	38
Олон улсын хамтын ажиллагаа	40
Хууль дүрмийн сонголт	40
Хариу үйлдэл үзүүлэх эрх бүхий этгээд	41
Онцгой нөхцөл байдал дахь ажиллагаа	41
Баталгаа ба татгалзах үндэслэл	42
Хавсралт А: Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд	
олон улсын хүний эрхийн зарчмуудыг баримтлах нь.....	43
Хавсралт В: Хяналтын жагсаалт	47
Хавсралт С: Жишээ баримт 1.....	49
Хавсралт D: Жишээ баримт 2.....	52

Тус гарын авлагыг Эми Степанович, Дрю Митник нар анх боловсруулсан юм. Access байгууллага болон зохиогчдын зүгээс дараахь хүмүүст гарын авлага бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, дэмжлэг туслалцаа үзүүлсэнд талархал илэрхийлж байна.

Валид Аль Сакаф
Кевин Банкстон
Рохана Басс
Жохай Бен-Ави
Бриттани Беновиц
Дебора Браун
Жек Бассел
Фабиола Кааррион
Алвберто Серда
Синди Кон
Ханни Факури
Томасо Фалчетта

Майк Годвтн
Натали Грийн
Эллонай Хикок
Арни Хинф
Мартин Хусовец
Тамир Израел
Зеке Жонсон
Ли Каспар
Прия Кумар
Жой Лиддикоат
Сьюзан Морган

Карли Нист
К.С.Парк
Александрине Пирло де Корбион
Катица Родригез
Наурин Шах
Сара Ст. Винсент
Амос Тох
Франчиско Вера
Тимоти Вагштаффе
Кате Вестмореланд
Синтия Вонг

Уг баримт бичгийг гүйцэтгэхэд цаг заваа зарцуулсан Access байгууллагын ажилтнууд болох Бретт Соломон, Петер Мичек, Реиган МакДоналд, Эстелле Массе, Хавиер Паллеро, Майкл Карбоне болон Риан Ванстрит нар талархал илэрхийлье.

Access нь дэлхийн өнцөг бүрт эрсдэлд өртсөн хэрэглэгчдийн цахим эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага юм.

Бид шинэлэг бодлого, хэрэглэгчийн оролцоо болон техникийн шууд тусламжийг хослуулан бүх нийтийн нээлттэй, аюулгүй харилцаа холбооны төлөө тэмцдэг.

Энэхүү удирдамжтай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл, туслалцаа авахыг хүсвэл info@accessnow.org цахим шуудангаар холбогдоно уу.

Зарчмуудын товч тайлбар

Харилцаа холбоог мөрдөн тагнахад баримтлах хүний эрхийн олон улсын зарчмууд нь харилцаа холбоог мөрдөн хянахдаа хүний эрхийн үүрэг, хариуцлагын үнэлэмжийн хүрээг баримтална.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛТЭЙ БАЙХ

Хувийн нууцтай байх эрхийн аливаа хязгаарлалтыг хуулиар урьдчилан тогтоосон байх ёстой.

ХУУЛЬ ЁСНЫ ЗОРИЛГОТой БАЙХ

Ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай эрх зүйн тэргүүлэх зэргийн ашиг сонирхолд нийцэхүйц хууль ёсны зорилгод хүрэхийн тулд төрийн эрх бүхий байгууллагаас харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулахыг гагцхүү хуулиар зөвшөөрнө.

ШААРДЛАГАТАЙ БАЙХ

Улс оронд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн хууль тогтоомж нь хууль ёсны зорилгод тодорхой, үр дүнтэй хүрэхийн тулд маш нарийн тодорхойлсон, зайлшгүй шаардлагатай хэмжээгээр л мөрдөн тагнах ажиллагааг хязгаарлавал зохино.

НИЙЦЭХҮЙЦ БАЙХ

Хуулиар тогтоосон харилцаа холбоог мөрдөн тагнах аливаа ажиллагаа нь тодорхой тогтоосон хууль ёсны зорилгыг бүрэн биелүүлэхэд нийцсэн байвал зохино.

ДҮЙЦЭХҮЙЦ БАЙХ

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай шийдвэрт нэвтэрсэн мэдээллийн эмзэг мэдрэмжтэй байдал хийгээд хүний эрхийн болон бусад янз бүрийн эрх ашгийг зөрчих эрсдлийг харгалзах ёстой.

ЭРХ МЭДЭЛ БҮХИЙ ШҮҮХИЙН БАЙГУУЛЛАГА

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаатай холбогдох шийдвэрийг эрх бүхий шүүх эрх мэдлийн хараат бус, шударга байгууллага гаргах ёстой.

ЗОХИХ ЁСНЫ АЖИЛЛАГАА

Улс орнуудаас хүний эрхэд халдсан аливаа хууль ёсны үйл ажиллагааг хуулинд сайтар зүйлчилж, тогтвортойгоор дагаж мөрдөн, олон нийтэд нээлттэй байдлыг хангаснаар хүний эрхийг хүндэтгэн сахин хамгаалахыг шаардана.

ХЭРЭГЛЭГЧДЭД МЭДЭГДЭЛ ӨГӨХ

Харилцаа холбоо мөрдөн тагнах ажиллагаанд өртөж буй хувь этгээдэд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг зөвшөөрсөн шийдвэрийн талаар давж заалдах гомдол гаргах, эрх зүйн бусад өмгөөлөл эрэлхийлэхэд хангалттай байхуйц хугацаанд мэдэгдэх шаардлагатай.

ИЛ ТОД БАЙДАЛ

Улс орнууд харилцаа холбоог мөрдөн тагнах тухай хуулийн хамрах хүрээ болон хэрэглээ, журам, үйл ажиллагаа, эрх мэдэл буюу эрх бүхий байгууллагын асуудлаар ил тод байх үүрэгтэй.

ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ

Улс орнууд нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор хяналтын хараат бус механизм бий болгох шаардлагатай.

ХАРИЛЦАА ХОЛБОО, СҮЛЖЭЭНИЙ ХАЛДАШГҮЙ БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ

Улс орнууд нь үйлчилгээ үзүүлэгчид, техникийн болон программ хангамжийн борлуулагчдыг сүлжээндээ мөрдөн тагнах ажиллагаа буюу мониторинг хийх чадавхийг бий болгох, эсвэл төрийн харилцаа холбоог мөрдөн тагнах зорилгоор тодорхой мэдээллийг цуглуулах, хадгалахыг албадах ёсгүй.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАТАЛГАА

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ (MLATs) болон улс орнуудын байгуулж буй бусад гэрээ хэлэлцээрүүд нь нэгээс дээш улсын хууль тогтоомж нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд нийцэх, хувь хүмүүст өндөр хэмжээний хамгаалалт өгсөн мөрдөгдөж буй хэм хэмжээг ашиглавал зохино.

ХУУЛЬ БУС ХАНДАЛТЫН ЭСРЭГ БАТАЛГАА БА ЭРХ ЗҮЙН ҮР НӨЛӨӨТЭЙ ХАМГААЛАЛТ АВАХ ЭРХ

Улс орнууд төрийн болон хувь этгээдийн зүгээс хууль бусаар харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг гэмт хэрэгт тооцсон хууль тогтоомжтой болсон байх үүрэгтэй.

Оршил

1. Танилцуулга

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулахад баримтлах хүний эрхийн олон улсын зарчмууд (цаашид "зарчмууд" гэх) нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах комиссын хүний эрхийн хүлээсэн үүрэг, чиг үүргийн үнэлэмжийн хүрээг тогтоож өгдөг. Access, Electronic Frontier Foundation - Цахим Хилийн сан, болон Privacy International байгууллагаас 2013 оны долдугаар сард өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулж, эдгээр зарчмыг боловсруулсан. Эдгээр зарчмууд нь 400 гаруй иргэний нийгмийн байгууллагуудын гарын үсэг зурж дэмжигдсэн бөгөөд нэлээдгүй улс орнууд, бүс нутагт хууль эрх зүйн шинэчлэлийн талаарх хэлэлцүүлэг мэтгэлцээнд иш татагдан яригдсан.¹

Энэхүү хэрэгжүүлэх гарын авлага нь Зарчмуудыг практикт хэрхэн баримталж ажиллах тухайд илүү дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан. Хувь хүний цахим мэдээллийг олж авахад Засгийн газрын өргөдлийн процесс ажиллагааны үе шат бүрийг, түүнчлэн Хэрэглэгчийн мэдээллийг олж авахаар процесс ажиллагаанд оролцож буй Засгийн газрын агентлагууд, шүүгчид, хуульчдад зориулсан шалгах хуудас, жишээг энэхүү гарын авлагад багтаасан болно. Энэ гарын авлага нь таван хэсэгт хуваагдана. Үүнд:

- Мэдээлэл авах тухай засгийн газрын өргөдөл;
- Шүүхээр хэлэлцэх ажиллагаа
- Хайлт хийх
- Давж заалдах гомдол гаргах болон эрх зүйн хамгаалалт авах
- Олон улсын хамтын ажиллагаа.

Эдгээр Зарчмууд нь бүрэн эхээрээ гарын авлагын Хавсралт А-д байгааг харна уу. Хавсралт Б-д бидний энд судлах асуудлын талаар туслах шалгах хуудсыг оруулсан. Хавсралт С болон D-д багтаасан жишээ баримтууд нь хүний эрхийг нэлээд хангасан мөрдөн тагнах ажиллагаа явуулахад нэмэлт мэдээлэл болох юм.

2. Хувийн нууц болон мөрдөн тагнах ажиллагааны хууль зүйн хүрээ

Хувийн нууцтай байх нь бидний хамгийн чухал эрхүүдийн нэг, угаас заяасан үнэт зүйлсийн нэг төдийгүй, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шилжин суурьших,

¹ See, e.g., Report and Recommendations of the President's Review Group on Information and Communications Technology, *Liberty and Security in a Changing World*, Dec. 12, 2013, fn. 120, available at http://www.whitehouse.gov/sites/default/files/docs/2013-12-12_rg_final_report.pdf; Annual Report of the Inter-American Commission on Human Rights, Dec. 31, 2013, available at <http://www.oas.org/en/iachr/docs/annual/2013/informes/LE2013-eng.pdf>.

эвлэлдэн нэгдэх, сэтгэлгээний эрх чөлөө болон шашин шүтэх² гэх мэт бусад үндсэн язгуур эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэс суурь нь болдог. Хувийн нууцтай байх эрх нь Олон улсын конвенциудаар хүлээн зөвшөөрөгдсөн, олон улс орнууд Үндсэн хууль болон үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байдаг³. Олон улсын хуулийн дагуу, хувийн нууцтай байх эрх нь “түүний хувийн нууцлал, гэр бүл, орон гэр, захидал харилцаанд хууль бусаар буюу дур мэдэн халдах”-гүй байх эрх гэж томъёологддог.⁴

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейгаас 2013 оны 12 дугаар сард баталсан тогтоолын мөрөөр Дээд комиссарын газраас 2014 оны долдугаар сард “Цахим эринд хувийн нууцтай байх эрх” гэсэн судалгаа хийж, тайланг хэвлэн нийтэлсэн⁵. Энэхүү тайланд Зарчмуудыг хэдэнтээ дурдаад, “хувийн нууцтай байх эрх, түүнийг хууль эрх зүйн хүрээнд болон амьдралд ч мөн адил халдашгүй дархан байлгах, сахин хамгаалах хэрэгцээ шаардлагыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна” хэмээн тэмдэглэжээ.⁶ 2014 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шинэ Тогтоол гарч, Улсуудыг харилцаа холбооны мөрдөн тагнах ажиллагааны хувьд хувийн нууцтай байх, халдашгүй дархан байх асуудлыг нэн тэргүүний зорилт болгож, түүнтэй холбогдсон журам, дадал хэвшил, хууль эрх зүйгээ дахин хянаж үзээд, шаардлагатай тохиолдолд нийцүүлэхийг уриалсан

² See Frank La Rue, *Report of the Special Rapporteur to the on the promotion and protection of the right to freedom of opinion and expression*, U.N. Doc. A/HRC/23/40 (April 17, 2013), available at http://www.ohchr.org/Documents/HRBodies/HRCouncil/RegularSession/Session23/A.HRC.23.40_EN.pdf.

³ International Covenant on Civil and Political Rights art. 17, Dec. 16, 1966, 999 U.N.T.S. 171 [hereinafter ICCPR]; European Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms, as amended by Protocols Nos. 11 and 14, Nov. 4, 1950, 213 U.N.T.S. 2889 [hereinafter ECHR]; American Convention on Human Rights art.11, Nov. 21, 1969, 1144 U.N.T.S. 143 [hereinafter ACHR]; see, e.g., The Charter of Fundamental Rights and Freedoms (Constitutional Amendment) Act 2011 (Jamaica), s.13(3)(k); Constitution of the Federative Republic of Brazil, art. 5; Constitution of the Republic of South Africa, s.14.

⁴ ICCPR art. 17. Article 11(2) of the ACHR states that “No one may be the object of arbitrary or abusive interference with his private life, his family, his home, or his correspondence, or of unlawful attacks on his honor or reputation.” Article 8 of the ECHR provides more direct guidance about the nature of permissible interferences; see also *Report of the Special Rapporteur on the promotion and protection of human rights and fundamental freedoms while countering terrorism*, Martin Scheinin, U.N. Doc. A/HRC/13/37, para. 17 (Dec. 28, 2009), available at <http://www2.ohchr.org/english/bodies/hrcouncil/docs/13session/A-HRC-13-37.pdf> (“The permissible limitations test, as expressed in the general comment, includes, inter alia, the following elements: (a) Any restrictions must be provided by the law (paras. 11-12); (b) The essence of a human right is not subject to restrictions (para. 13); (c) Restrictions must be necessary in a democratic society (para. 11); (d) Any discretion exercised when implementing the restrictions must not be unfettered (para. 13); (e) For a restriction to be permissible, it is not enough that it serves one of the enumerated legitimate aims; it must be necessary for reaching the legitimate aim (para. 14); (f) Restrictive measures must conform to the principle of proportionality; they must be appropriate to achieve their protective function; they must be the least intrusive instrument amongst those which might achieve the desired result; and they must be proportionate to the interest to be protected (paras. 14-15); (g) Any restrictions must be consistent with the other rights guaranteed in the Covenant (para. 18).” (internal citations omitted)); UN Human Rights Committee (HRC), *CCPR General Comment No. 27: Article 12 (Freedom of Movement)*, Nov. 2, 1999, CCPR/C/21/Rev.1/Add.9, available at <http://www.refworld.org/docid/45139c394.html>.

⁵ *The Right to Privacy in the Digital Age*, G.A. Res. 68/167, U.N. Doc. A/RES/68/167 (Jan. 21, 2014); *The Right to Privacy in the Digital Age: Rep. of the Office of the United Nations High Commissioner for Human Rights*, U.N. Doc. A/HRC/27/37 (June 30, 2014), available at http://www.ohchr.org/EN/HRBodies/HRC/RegularSessions/Session27/Documents/A.HRC.27.37_en.pdf.

⁶ *Id.* at 5.

байна. Мөн тус Тогтоолоор Хүний эрхийн зөвлөлд хувийн нууцын эрхтэй холбоотой тусгай процедурыг бий болгох хүсэлт тавьснаар, 2015 оны 3 дугаар сард тус журмыг баталж, хувийн нууцтай байх эрхийн төлөөх тусгай төлөөлөгчийг томилсон байна⁷.

Хувийн нууцтай байх эрх гэдэгт тодорхой зайлшгүй шаардлага бүхий журмын болон бодит шинж чанартай хамгаалалтууд багтана⁸. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссийн тайланд олон улсын хууль тогтоомжоор “хувийн нууцтай байх эрхийг дэмжиж, хамгаалсан маш тодорхой нэгдсэн зохицуулалт” бүрдсэн боловч, олон улсууд “үүнтэй холбоотой үндэсний хууль тогтоомжтой байх, дотооддоо хэрэгжүүлэх талаар дутагдалтай, тодорхой журамласан хамгаалалтууд нь сул бөгөөд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж чадахгүй” байсаар байгааг тусгасан байна.⁹ Эдгээр ойлголтуудыг бодит байдал дээр хэрэгжүүлэх нь хэзээд бэрхшээлтэй байсаар ирсэн. Түүнчлэн, орчин үеийн технологиуд мөрдөн тагнах ажиллагааг илүү хямд төсөр, хялбар болгосон нь саад тотгорыг хэд дахин нэмэгдүүлээд зогсохгүй, хувийн нууцтай байх эрхийг хамгаалах асуудлыг улам бүр хумигдуулж байна. Үүнээс гадна, бусад ээдрээтэй асуудлууд, хууль тогтоомж, зохицуулалтууд, албан ёсны процедурууд нь сунжрах хандлагатай тул орчин үеийн технологийн хөгжлийн хурдыг гүйцэхгүй, орхигдож байна.

2013 оны 6 дугаар сард НҮБ-ын Тусгай илтгэгч Франк Ла Ру Засгийн газраас харилцааны холбоог мөрдөн тагнах үйл ажиллагаатай холбоотой чухал тайлан гаргасан байдаг. Ноён Ла Ру тайлангийн дүгнэлтэд олон улсын хүний эрхийн тухай хууль эрхийг тодорхой заасныг үл харгалзан¹⁰, тэдгээр хууль тогтоомж болон процедурыг тодорхой нэг тохиолдолд хэрхэн ашиглах талаар хувь хүмүүс, төр засгийн удирдлагууд тодорхой зааварчилгаа дутмаг байна. Зарчмууд нь хоосон орон зайг нөхөж байгаа бөгөөд энэхүү Хэрэгжүүлэх удирдамж нь Зарчмуудтай хослуулан ашиглах зориулалттай.¹¹ Хэрэгжүүлэх удирдамж нь хүний эрхтэй холбогдсон одоогийн хууль эрх зүйн ойлголтод суурилсан бөгөөд хууль хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлын болон бусад төрлийн зохицуулалт хийх зорилгоор цахим харилцаа холбоог мөрдөн тагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар үүрэг хариуцлага хүлээхийг тайлбарласан байна¹².

⁷ *The Right to Privacy in the Digital Age*, G.A. Res. 69/166, U.N. Doc. A/RES/66/166 (Feb. 10, 2015); *Human Rights Council Agenda Item 3, The Right to Privacy in the Digital Age*, 28th Sess., A/HRC/28/L.27 (Mar. 24, 2015) [final pending].

⁸ ICCPR art. 17, Declaring both a substantive right to privacy and procedural rights under the law.

⁹ *Supra*, note 5, at 16.

¹⁰ La Rue, *supra* note 2.

¹¹ See, e.g., Stop Watching Us (Sept. 17, 2014), StopWatching.US.

¹² UN Commission on Human Rights, *The Siracusa Principles on the Limitation and Derogation Provisions in the International Covenant on Civil and Political Rights*, Sept. 28, 1984, E/CN.4/1985/4, available at [Error! Hyperlink reference not valid.](#); see also OTI report by Danielle Kehl.

Удирдамжид ашигласан нэр томъёо

Хэрэглэгчийн хаяг

гэдэг нь хэрэглэгч, байгууллага, сүлжээ, компани буюу бусад аливаа талууд болох бусад хуулийн этгээд болон чиглэсэн этгээдийн хоорондын харилцан хамаарлыг тогтоохын тулд бий болгосон бүртгэл буюу бүртгэлийн цуглуулга юм.

Шүүгч

гэж хүчин төгөлдөр хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах эрх бүхий шүүхийн байгууллагын албан тушаалтанг хэлнэ.

Харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдөл буюу өргөдөл

гэж харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах бүрэн эрх олж авахаар чармайж буй байгууллагаас шүүх /засаглалын/ эрх мэдлийн байгууллагад гаргасан баримт бичгийг хэлнэ.

Харилцаа холбоо

гэдэг нь тухайн нэг хэрэглэгч болон бусад аливаа этгээд (үүнд: өөр бусад ямар ч хэрэглэгч, байгууллага, сүлжээ, компани, эсхүл бусад тал байж болно) хооронд мэдээлэл эсхүл өгөгдөл хуваалцах, хүлээн авах, харилцан солилцох үйл ажиллагаа гэж ойлгоно. Харилцаа холбоо гэдэгт түүний агуулга, аливаа метадата багтана. Үүнд: бүртгэгдсэн хэрэглэгчийн мэдээлэл, оролцогч талын үндсэн мэдээлэл, биометрик мэдээлэл, байршлын мэдээлэл, IP хаяг, харилцаа, холбооны цаг, үргэлжлэх хугацаа, ашиглагдаж буй холбооны тоног төхөөрөмж, үзүүлэлт зэрэг багтах боловч түүгээр хязгаарлагдахгүй.

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа

гэж мониторинг, дундаас нь барих, цуглуулах, олж авах, шинжлэх, ашиглах, нөөцлөх, хадгалах, саатуулах хандах, үнэлэх, эсхүл түүнтэй адил төстэй үйл ажиллагаа орно. Мөн урьд нь тусгасан, өнгөрсөн, одоо, ирээдүйн хүний харилцаа холбооны тухай байх эсвэл түүнд багтах, нөлөөлөх, түүнээс гарч ирэх мэдээллийн талаар төсөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хэлнэ.

Харилцаа холбоог мөрдөн тагнахыг зөвшөөрсөн шүүхийн тогтоол буюу шүүхийн тогтоол

гэж аливаа хүний өнгөрсөн, одоо, ирээдүй дэх харилцаа холбоог өөртөө багтаасан, түүн дээр тулгуурласан, түүнээс улбаалсан, эсхүл тухайн хүний хувийн мэдээллийг хянах, саатуулах, цуглуулах, олж авах, шинжлэх, ашиглах, хадгалах, авч үлдэх, дундаас нь барьж авах, нэвтрэх болон бусад ижил төстэй үйлдэлтэй холбоотойгоор Шүүхийн эрх бүхий байгууллагаас гаргасан аливаа баримт бичиг хэмээн ойлгоно.

Төхөөрөмж

гэж цуглуулах, дамжуулах, хадгалах буюу мэдээллийг холбох, эсхүл мэдээлэл цуглуулалт, дамжуулалт, хадгалалт, буюу мэдээллийн холболтыг хялбарчлахад чиглэсэн этгээдийн хэрэглэж буй механик тоног төхөөрөмжийн аль ч хэсгийг хэлнэ.

Олон улсын албан ёсны шугам

Шүүхийн харъяалал хоорондын хэрэглэгчийн өгөгдлийг солилцох үйл явц юм. Ямар ч олон улсын албан ёсны шугам нь олон шүүхийн харъяалалтай нөхцөлд аль хуулийг дагаж мөрдөхийг тодорхойлсон удирдамжаар хангаж, хамгаалагдсан мэдээллийг ойлгомжтой тодорхойлж, түүнийг олж авахын тулд шүүхийн зөвшөөрөл авах, илүү нууц адармаатай мэдээллийн хувьд илүү өндөр түвшний нотолгооны босгыг хэрэглэх, онцгой нөхцөл байдлын дагуу мэдээлэл солилцох талаар ойлгомжтой удирдамжаар хангана.

Хэрэглэгч

гэдэгт аливаа нэг хувь хүнийг ойлгоно.

Хэрэглэгчийн өгөгдөл

Ирсэн, явсан, хэрэглэгчийн бүтээсэн эсвэл түүний тухай мэдээлэл, өгөгдөл хамаарна.

Мэдээлэл авах талаарх Засгийн газрын өргөдөл

1. Өргөдөл гаргах эрх мэдэлтэн

Харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдөл нь хуульд заасан журмын дагуу хийгдэх ёстой.

Холбогдох зарчим (ууд): хууль ёсны үндэслэлтэй байх

Харилцаа холбооны мөрдөн тагнах ажиллагаа явуулах Засгийн газрын агентлагийн чадвар нь олон улсын хүний эрхийн хуульд нийцүүлэн баталсан хуулиар эрх олгосон, олон нийтээр хүлээн зөвшөөрсөн хэмжээнд байх ёстой. Энэ хууль нь нээлттэй мэтгэлцээнээр хэлэлцэгдэж, олон нийтийн хэлэлцүүлгээр батлагдсан бөгөөд өөр ямар нэгэн нууц баримт бичиг, үзэл бодлоор өөрөөр тайлбарлагдах, буюу өөрчлөгдөх боломжгүй байх ёстой. Засгийн газрын агентлагууд эдгээр заалтыг хатуу чанд дагаж мөрдөх ёстой.

Хэрэгжүүлж буй жишээ:

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 16 дугаар Ерөнхий тайлбараар ИБУТЭТОУП-ын 17 дугаар зүйлд тайлбар хийсэн.¹³ “Хуулиар урьдчилан зааж, тогтсон тохиолдлоос бусад аливаа хөндлөнгийн оролцоо биш бол түүнийг ‘Хууль бус’ гэж ойлгоно. Төрөөс хүлээн зөвшөөрсөн хөндлөнгийн оролцоо нь зөвхөн хуульд үндэслэнэ. Уг хууль нь Пактын зүйл заалтууд, зорилго болон зорилтод нийцсэн байх ёстой”.¹⁴ “Хүлээн зөвшөөрч болох хөндлөнгийн оролцоог нарийн нягт байдлаар холбогдох хууль тогтоомжид маш тодорхой нарийвчлан зааж өгөх ёстой. Энэхүү хуулиар тогтоосон, хүлээн зөвшөөрөхүйц хөндлөнгөөс оролцох шийдвэрийг эрх бүхий байгууллагаас гаргахдаа тохиолдол тус бүр дээр шалгаж, баталгаажуулах үүрэгтэй.”¹⁵

¹³ [13] According to international standards, in developing Communications Surveillance laws, “[e]verybody should be informed and consulted in the process of law drafting” with limited exceptions. Provided information should clearly explain the issues addressed issues and extra precautions should be taken to ensure civil society involvement. *Transparency and Public Participation in Law Making Processes*, pg. 6-7, [Organization for Security and Co-Operation in Europe, Oct. 2010, available at http://www.ecnl.org/dindocuments/381_Transparency%20in%20Law%20Making%20Eng.pdf](http://www.ecnl.org/dindocuments/381_Transparency%20in%20Law%20Making%20Eng.pdf).

¹⁴ UN Human Rights Committee (HRC), *CCPR General Comment No. 16: Article 17 (Right to Privacy), The Right to Respect of Privacy, Family, Home and Correspondence, and Protection of Honour and Reputation*, April 8, 1988, available at: <http://www.refworld.org/docid/453883f922.html>.

¹⁵ *Id.*

2. Хайлт хийх хэрэгцээ шаардлага

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа нь өчүүхэн төдий боловч халдлагын шинжгүй арга хэмжээ авах хүсэлтэд л зөвхөн хэрэглэгдэнэ.

Холбогдох зарчим (ууд): зайлшгүй шаардлага, дүйцэхүйц ба тэнцвэртэй байх

Хамгаалагдсан мэдээллийг олж авахаар хайлт хийхийн тулд төрийн агент тодорхойлсон хууль ёсны зорилгод хүрэхэд шаардлагатай байгаа мэдээллээ олж авахаар хэрэглэх арга нь маш өчүүхэн боловч халдлага түрэмгийллийн шинж агуулаагүй харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулна гэдгээ баттай нотлох ёстой.

Үүнийг хийхийн тулд төрийн агент нь шаардлагатай мэдээллийн хүрээг нарийвчлан тодорхойлох ёстой. Энэ нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа нь чиглэсэн этгээд, хууль ёсны зорилго, эсвэл бүртгэл, төхөөрөмж болон мэдээлэл агуулагчид хайлт хийхтэй холбоотой байх нь хангалтгүй юм. Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны цар хүрээг бусад хамгаалалттай мэдээлэлд үзүүлэх нөлөөлөл хамгийн бага байлгах тэр хэмжээтэй маш явцуу тохируулсан байх ёстой.¹⁶

Хэрэгжүүлж буй жишээ:

Канад улсын Эрүүгийн хуулийн §186 (1) (б)-д "бусад мөрдөн байцаах ажиллагаа амжилттай болох итгэл найдваргүй" үед утасны яриаг замаас нь сонсохыг мөрдөн байцаах тохиромжтой арга хэрэгсэл болохыг хүлээн зөвшөөрдөг".¹⁷ Канадын Дээд шүүхээс Араужод холбогдох хэрэгт "эрүүгийн мөрдөн байцаах ажиллагаа явуулах болон хувийн нууцтай байх эрхийг хамгаалах хоёр нь өрсөлдүүлэн жинлэж үзэх боломжтой асуудлууд юм" хэмээн тайлбарласан.¹⁸ Иймээс, мөрдөн байцаах ажиллагаа хэрэгцээ шаардлагатай болох шалгуурыг хангахын тулд цагдаагийн байгууллагаас мөрдөн байцаахаас бусад тохиромжтой, хамгийн багаар халдах өөр арга байхгүй гэдгийг тогтоох ёстой.

¹⁶ Chaparro Alvarez v. Ecuador, Judgement, Inter-Am. Ct. H.R. (ser. C) No. 170 (Nov. 21, 2007), available at <http://observatoriovihycarceles.org/en/hiv-and-prison-menu/jurisprudence-prison-menu.raw?task=download&fid=505>.

¹⁷ Criminal Code, R.S.C. 1985, c. C-46 (Can.).

¹⁸ *R v Araujo* [2000] 2 S.C.R. 992 (Canada), available at <https://scc-csc.lexum.com/scc-csc/scc-csc/en/item/1830/index.do>.

3. Өргөдлийн хэлбэр

Харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдлийг Шүүх эрх мэдлийн байгууллагад гаргах бөгөөд:

- Хүсэлт гаргаж буй агентлаг, албан тушаалтныг маш тодорхой дурдсан байх
- Өргөдөлд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит, найдвартай болохыг баталгаажуулсан байх

Холбогдох зарчим (ууд): Зохих ёсны ажиллагаа

Хамгаалагдсан мэдээллийг олж авах зорилгоор төрийн агент нь шүүх эрх мэдлийн байгууллагад харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдлөө бичгээр гаргах ёстой. Уг өргөдөлд хандалт хийхийг хүсч буй төрийн агентын нэр, түүний албан тушаал, хүсэлтээ өөрийнхөө эрх бүхий байгууллагад танилцуулсан талаарх баталгаа болон түүнд дурдагдсан бүх мэдээллийн үнэн зөвийг гэрчилсэн гарын үсэг заавал байх ёстой. Харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн төрийн агентын өргөдлийн материалуудыг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуульд маш тодорхой тусгагдсан байдаг.¹⁹ Түүний хувь хүний байдал буюу албан тушаалыг харгалзахгүйгээр төрийн агент нь ил тод байдлыг хангаж, энэхүү гарын удирдамжид дурдагдсан хуулиуд болон холбогдох бүхий л хууль тогтоомжийн дагуу (доороос харна уу) өргөдөлд агуулагдаж буй мэдээллийн төлөө хариуцлагыг үүрэх бөгөөд худал мэдүүлэг өгвөл эрүүгийн ял хүлээх ёстой.

Хэрэгжүүлж буй жишээ:

АНУ-д баталгаажуулалтыг батлан даалт, зарлан дуудах хуудас, эсвэл бусад хэрэгсэлтэй хамт амлалт өгсөн гэрчийн бичгэн мэдүүлэг хэлбэрээр авч болно.

¹⁹ [19] In common law countries, the application will typically be made by the law enforcement officer, whereas in civil law countries it is more common that the application be made by prosecutors. The Principles accommodate either system.

3. Өргөдлийн агуулга

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах өргөдөлд дараах зүйлийг нарийн тодорхойлсон байвал зохино. Үүнд:

- Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны хүрэхийг зорьж буй хууль ёсны зорилго болон тэрхүү хууль ёсны зорилгодоо хүрэхийн тулд хайж олох хэрэгцээ шаардлагатай байгаа мэдээлэл
- Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны чиглэсэн этгээд (Хэрэв энэ нь мэдэгдэхгүй бол өргөдөлд хамаарах бодит чиглэсэн этгээдийг тодорхойлж болох чиглэсэн этгээдийг тодорхойлохтой холбоотой бүхий л боломжит баримт фактууд байх)
- Холбогдох хууль тогтоомжоор харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн байх болон
- Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны зөвшөөрөл хүссэн хүрээг нарийн тогтоох

Холбогдох зарчим (ууд): Хууль ёсны зорилготой байх, Нийцэхүйц байх, Шаардлагатай байх болон Дүйцэхүйц байх

Харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн бүхий л өргөдөлд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны хууль ёсны зорилго, энэхүү хууль ёсны зорилгод хүрэхэд хэрэгцээ шаардлагатай байгаа мэдээлэл яг юу болох, яагаад гэдгийг тайлбарласан байвал зохино. Хамгаалагдсан мэдээлэлд нэвтрэхийг оролцуулаад харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах нь яагаад зайлшгүй шаардлагатай байгааг өргөдөлд тайлбарлана. Мөн өргөдөлд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах чиглэсэн этгээдийг аль болох бүх талаас нь тодорхойлсон байх ёстой. Чиглэсэн этгээд нэмэгдэх бүрт шинээр өргөдөл гаргах шаардлагатай.

Эцэст нь, өргөдөлд хүсэлт гаргасан харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны хамрах хүрээг нарийн тодорхойлон тогтоосон байвал зохино. Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах бүртгэл, төхөөрөмж болон мэдээлэл агуулагчийг тодорхойлж, хамрах хүрээг зөв тогтоох хэрэгтэй. Ялангуяа түүний өгөгдлийн сан, нэвтрэх гэж буй хамгаалагдсан мэдээлэл, хэрэглэгдэж буй нэр томъёотой ямар нэг хамааралгүй байх, хууль ёсны зорилгоор тодорхойлогдсон хэрэгцээ шаардлагатай байгаа мэдээлэлтэй холбоотой өгөгдлийн сан болон тодорхой бүртгэл, төхөөрөмж болон мэдээлэл агуулагчид хандах хэрэгтэй.

Хэрэгжүүлж буй жишээ:

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)-ын зүйл заалтыг хязгаарлах болон хэсэгчлэн өөрчлөх тухай Siracusa зарчмуудаар үндэсний

аюулгүй байдалд үндэслэн хүний эрхэд хязгаарлалт тогтоосон нөхцөл байдлыг тайлбарладаг.²⁰ Хэдийгээр албан бус боловч Siracusa зарчмуудыг ИБУТЭТОУП-ын үндэслэл бүхий үнэмшилтэй тайлбар гэж үзэж байна.

5. Нотлох үүрэг

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах өргөдөл нь шүүх эрх мэдлийн байгууллагад нотлон харуулж чадахуйц хангалттай мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанаас хэрэгцээ шаардлагатай мэдээллийг гаргаж ирэх
- Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулахаар тодорхойлсон бүртгэл, төхөөрөмж, мэдээлэл агуулагчид хайж буй хэрэгцээ шаардлагатай мэдээлэл нь агуулагдсан байх.
- Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулахаар тогтоосон хүрээ нь хэрэгцээ шаардлагатай мэдээллийг олж авах шаардлагыг хэтрүүлэхгүйгээр хамгаалагдсан мэдээллээс гаргаж ирэхээр тодорхойлсон байх

Холбогдох зарчим (ууд): Хууль ёсны зорилготой байх, Нийцэхүйц байх, болон Дүйцэхүйц байх.

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах өргөдөл нь дэмжигдэх үндэслэлтэй байх ба "fishing expedition" буюу "өгөгдөл өгч турших" аргын нэг хэсэг байж болохгүй. Төрийн агент нь нийтийн албаны хуулиар нэн тодорхой заасанчлан, харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдөлдөө уг ажиллагааг явуулах бүртгэл, төхөөрөмж, эсхүл мэдээлэл агуулагч болон тодорхойлогдсон хэрэгцээ шаардлагатай байгаа мэдээллийн хооронд хангалттай холбоо хамааралтайг нарийвчлан харуулахуйц мэдээллээр бүрэн хангах үүрэгтэй. Энэхүү нотлох үүргээ биелүүлэхийн тулд төрийн агент нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах шаардлагатайг дэмжсэн батлан харуулах үйлдэл, эс үйлдэл болон тэрхүү үйлдэл, эс үйлдэл нь бодитой болж буйд итгүүлэх нотолгооны үндэслэлээр хангахуйц хууль ёсоор олж авсан баримтыг оруулсан байх ёстой. Өргөдөл дэх баримтууд нь хамгийн боломжит хэмжээндээ олж авах, харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах хүрээ, хэрэгцээ шаардлагатай мэдээллийг олж авахын тулд хамгаалагдсан мэдээлэлд хамгийн багаар хамруулахуйц зохистой, нарийн тогтоосон хайлт хийхэд хэрэглэгдэх нэр томъёо цаашид дэмжлэг болох ёстой.

²⁰ UN Commission on Human Rights, *supra* note 11.

Хэрэгжүүлж буй жишээ:

АНУ-д, батлан даалтад авахын тулд нотлох баримт нь АНУ-ын Үндсэн хуулийн дөрөв дэх нэмэлт өөрчлөлтийн шаардлагын дагуу "Үндэслэл бүхий шалтгаан"-ы стандарт нөхцөлийг хангасан байх ёстой. "Үндэслэл бүхий шалтгаан нь" хэмээх ойлголтыг "Гэмт хэргийн нотлох баримт эсвэл контрабандыг нь тодорхой нэг газарт олж болох хангалттай үндэслэл байх" гэж тайлбарласан байна.²¹ Зөвшөөрөл авах өргөдөл нь "үндэслэл бүхий шалтгаан"-ыг тогтооход хангалттай нотлох мэдээлэл агуулсан байна. Ингэхдээ эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнг нотлох эсвэл гэмт хэргийн үр дагавар, гэмт хэргийн аргаар олж авсан эд хөрөнгө, контрабандыг илчлэхүйц нотлох баримт хайхад итгэлтэй байх нь зүйтэй. Хайлт хийх зөвшөөрлийн өргөдөлд хайж буй нотлох баримтыг тодорхой байршилд олж чадах, түүнчлэн хураан авах эд зүйлсийг нарийвчлан тогтоосон, тэднийг тодорхойлох (жишээ нь, тодорхой хугацааны хоорондох тусгайлан бичлэг хийх эсвэл гэмт хэргийн улмаас бий болсон тодорхой нэг хувь хүний өмчийг асуух зэргээр)-ын тулд хангалттай нарийвчилсан байвал зохино.

6. Онцгой ажиллагааны журам

Онцгой ажиллагааны журмыг онц байдлын нөхцөл шаардлагад дурдсан тодорхой нөхцөлд хэрэглэнэ.

Холбогдох зарчим (ууд): Хууль зүйн үндэслэлтэй байх, Зохих ёсны үйл ажиллагаа, болон Хууль бус хандалтын эсрэг аюулгүйн арга хэмжээ авах

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулахад өөр арга замаар эрх олгох, түүнийг хэрэглэхээр онцгойлон заасан бий болсон нөхцөлд онцгой ажиллагаагаар харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны саналыг нэн даруй гаргаж болно. Онцгой ажиллагааг тус ажиллагааны нөхцөл шаардлагад урьдчилан тодорхойлсон нөхцөлд л хэрэглэнэ. Онцгой ажиллагааны нөхцөл шаардлагад заасны дагуу онцгой ажиллагааны журмыг хэрэглэхээр шийдсэн тухай мэдэгдлийг онцгой ажиллагааны журмыг хэрэглэнэ хэмээн мэдэгдэл өгч буй харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг явуулж эхлэхээс өмнө урьдчилан өгөх ёстой. Гэсэн хэдий ч, төрийн агент онцгой ажиллагааны нөхцөл шаардлагын баримт бичигт байхгүй болох нь хэдий ч тогтоогдсон бол хайлт хийхийг нэн даруй зогсоож, ердийн журамд шилжүүлнэ.

Онцгой ажиллагааны журмыг хэрэглэхээр шийдсэн тухай мэдэгдэлд ажиллагааны нөхцөл шаардлагад тусгагдсан болохыг, энэхүү онцгой ажиллагааны нөхцөл шаардлага нь стандартад хэрхэн нийцэж байгааг маш тодорхой илэрхийлэх ёстой.

²¹ [21] *Illinois v. Gates*, 462 U.S. 213, 238 (1983).

Хайлт хийх санал гаргаснаас хойш аль болох богино хугацаанд харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдлийг хуулиар тогтоосон хугацааны дотор, болбол хайлт хийх санал гаргаснаас хойш 24-72 цагийн дотор бөглөж өгсөн байх шаардлагатай.

Зөвхөн нотлох баримт устгах буюу оргон зайлах эрсдэл нь онцгой ажиллагааны журмыг хэрэглэх хангалттай үндэслэл болох ёсгүй гэдгийг анхаарвал зохино.

Хэрэгжүүлж буй жишээ:

Бүгд Найрамдах Солонгос улсад хувь хүний амь насаа алдах, шархдах аюул учрахуйц онц ноцтой гэмт хэргийн заналхийсэн эрсдэл байгаа нөхцөлд мөрдөн байцаах албан хаагч нь шүүхийн зөвшөөрөлгүйгээр электрон мөрдөн тагнах ажиллагаа явуулж болдог. Гэхдээ уг албан хаагч нь мөрдөн тагнах ажиллагаа явуулж эхэлснээс хойш 36 цагийн дотор ийм ажиллагаа явуулж байгаа тухай шүүхээс зөвшөөрөл авах ёстой.²²

²² Protection of Communications Secrets Act, art. 8, Act n. 6626/2002, Jan. 2002, *available at* https://www.imolin.org/doc/amliid/Republic_of_Korea_Protection_of_Communications_Secrets_Act.pdf.

Шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа

1. Шүүн таслах эрх бүхий байгууллага

Харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдлийг хараат бус, бие даасан шүүхийн эрх бүхий байгууллага хянах ёстой.

Холбогдох зарчим (ууд): Эрх бүхий шүүхийн эрх мэдлийн байгууллага, Зохих ёсны ажиллагаа болон Олон нийтийн хяналт

Өргөдлийн агуулга, хангалттай үндэслэлтэй байдлыг тогтоосон шүүх эрх мэдлийн байгууллагын шийдвэр гарснаар харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах бүхий л өргөдөл нь хүлээн зөвшөөрөгдөх ёстой.

Шүүх эрх мэдлийн байгууллага нь бүрэн эрхтэй, хараат бус, бие даасан байх ёстой.²³ Энэхүү зарчимд тайлбарласнаар, шүүх эрх мэдлийн байгууллага гэж харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулдаг төрийн агентын харьяалагддаг салбараас бие даасан, тусдаа байх ёстой.

Шүүгч нь хүмүүст хандсан техникийн болоод үйл ажиллагааны мэдлэг мэдээлэлтэй шийдвэр гаргах чадвартай байхын тулд хангалттай сургалтад хамрагдсан, бусад шаардагдах туршлага эзэмшсэн байвал зохино. Шүүх эрх мэдлийн байгууллагын хэрэг хэлэлцэх ажиллагаа нь олон нийтийн өмнө, ил тод байх ёстой бөгөөд түүний шийдвэрийг хэвлэн нийтэлдэг байх ёстой. Шүүгч нь цаг алдалгүй мөрдөн шалгах шаардлагатай өргөдөлд шуурхай хариу өгч чадахуйц баталгааг хангах болон ялангуяа, онцгой ажиллагааны журмыг хэрэглэх шаардлагатай тохиолдлыг хязгаарлахын тулд улс орнууд хангалттай санхүүжилтийг хуваарилдаг байх хэрэгтэй.

Хэрэгжүүлж буй жишээ:

Хүний хувийн мэдээлэлд хууль бусаар буюу дур мэдэн оролцохыг хориглосон ИБУТЭТОУП-ын 17 дугаар зүйлийн тайлбарт Улс орнуудын хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд шүүн таслах ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах шаардлагатайг Хүний эрхийн хороо онцлон тэмдэглэжээ.²⁴

²³ Domestic and international laws enshrine the right to access to justice and fairness in a legal proceeding, with judges playing a prominent role in guaranteeing these protections. See La Rue, *supra* note 2, for discussion of the importance of an independent judiciary to adjudicate issues impacting on freedom of expression.

²⁴ See e.g., UN Human Rights Committee, *Concluding Observations of the Human Rights Committee Poland*, UN Doc. CCPR/C/79/Add.110, July 29, 1999, available at http://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=CCPR/C/79/Add.110 (“As regards telephone tapping, the Committee is concerned (1) that the Prosecutor (without judicial consent) may permit telephone tapping; and (b) that there is no independent monitoring of the use of the entire system of tapping telephones.”); *UN Human Rights*

Хэрэгжүүлж буй жишээ:

Швед улсад, Мөрдөн тагнах ажиллагааг хууль ёсны дагуу, маш өчүүхэн ч болов халдлага зөрчилгүй явуулахаа баталгаажуулахын тулд тагнуулын өгөгдлийг цуглуулахаар төлөвлөсөн тангуулын сигнал мэдээллийг Батлан хамгаалах тагнуулын шүүхээр заавал батлуулах ёстой. Мөрдөн тагнах ажиллагааны ач холбогдол нь хүний эрхэд халдлахаас илүү жинтэй байгаад шүүхээс мөн үнэлэлт дүгнэлт өгнө.²⁵

2.Өргөдлийн үндэслэл бүхий байдал

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай шүүхийн шийдвэр нь зөвхөн шүүх эрх мэдлийн байгууллагаас тогтоосон бол хүчинтэй байна. Харилцаа холбоог мөрдөн тагнах өргөдлийн бодит байдлыг нь эрх зүйн хувьд үндэслэлтэй байдал, үнэнийг нотлох ажиллагааг хамааруулан хянан шийдвэрлэх ажиллагааны шаардлагуудад нийцсэн гэдгийг тодорхойлж тогтоосон байх ёстой.

Холбогдох зарчим (ууд): Хууль ёсны үндэслэлтэй байх, Зохих ёсны ажиллагаа, Хууль ёсны зорилго, Зайлшгүй шаардлагатай байх, Тохирохуйц байх, болон Нийцэхуйц байх

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай шүүхийн шийдвэр нь уг өргөдөл нь эрх зүйн үндэслэлтэй байх бүхий л шаардлагууд болон хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг дээр дурдсанчлан дагаж мөрдсөн гэдгийг шүүх эрх мэдлийн байгууллагаас тодорхойлж тогтоосон үед зөвхөн хүчинтэй байна. Маргаан шийдвэрлэгч харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах өргөдөл нь дээр дурдсанчлан бүхий шаардлагатай мэдээллийг агуулсан гэдгийг баталгаажуулан, бие даасан, хараат бусаар хариуцлага хүлээнэ. Үүнд маргаан шийдвэрлэгч хангалттай байдлыг нотлох нэмэлт мэдээлэлгүйгээр нотлох баримтын стандартыг бүрэн хангасан болохыг тодорхойлж чадахуйц хангалттай нотолгоог нарийвчлан авсан байвал зохино (доороос харна уу).

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах өргөдлийн агуулгыг үнэлэхдээ маргаан шийдвэрлэгч нь хууль ёсоор олж авсан, хангалттай үндэслэл болохуйц мэдээлэлд тулгуурлана. Төрийн агент нь түүний үнэнийг нотолж буй

Committee, Concluding Observations of the Human Rights Committee, UN Doc. CCPR/C/79/Add.89, April 6, 1998, available at http://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=CCPR/C/79/Add.89. (“The Committee recommends that steps be taken to ensure that interception be subject to strict judicial supervision and that the relevant laws be brought into compliance with the Covenant”).

²⁵ The Law Library of Congress, *Foreign Intelligence Gathering Laws*, December 2014, 34, available at <http://www.loc.gov/law/help/foreign-intelligence-gathering/foreign-intelligence-gathering.pdf>.

баримтыг авч тодорхойлон тогтоох явцдаа аливаа мэдээлэл нь энэхүү стандартын шаардлагад нийцэхгүй байна гэж үзэх бол авч хэлэлцэхгүй.

3. Нотлох баримтын стандарт

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай шүүхийн шийдвэр нь маргаан шийдвэрлэгч харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа нь (дээрээс харна уу) зайлшгүй шаардлагатай хэмээн тогтоосон тохиолдолд гагцхүү хүчинтэй байна. Бүртгэл, төхөөрөмж, тээгч сан/ өргөдлийн бодит байдлыг нь эрх зүйн хувьд, үндэслэлтэй байдал, үнэнийг нотлох ажиллагааг хамааруулан хянан шийдвэрлэх ажиллагааны шаардлагуудад нийцсэн гэдгийг тодорхойлж тогтоосон байх ёстой.

Холбогдох зарчим(ууд): Тохирохуйц байх, Хууль ёсны зорилго, Нийцэхүйц байх Шаардлагатай байх

Тухайн тодорхойлсон хууль ёсны зорилгодоо хүрэхийн тулд тухайлсан зайлшгүй шаардлагатай мэдээлэл олж авахад халдлагыг хамгийн бага байлгах аа илэрхийлсэн тохиолдолд л зөвхөн шүүх эрх мэдлийн байгууллагаас харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах зөвшөөрөл олгоно. Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг гүйцэтгэх ёстой бүртгэл, төхөөрөмж, хадгалагч болон хайж буй зайлшгүй чухал мэдээлэл хоорондоо хангалттай холбоо хамаарал байгааг харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах хүрээ нь зайлшгүй чухал мэдээллийг олж авахад шаардлагатай байгаа хамгаалагдсан мэдээллээс илүүгүй хамрах нь нарийн нийцэж тохирсон гэдгээ төрийн агентаас нотолсон болохыг шүүхийн тогтоол гарахаас өмнө шүүх эрх мэдлийг байгууллагаас зайшгүй тогтоох шаардлагатай.

Хэрэгжүүлж буй жишээ:

АНУ-д зөвшөөрөл авахын тулд тухайн нотлох баримт нь АНУ-ын Үндсэн хуульд оруулсан дөрөв дэх нэмэлт өөрчлөлтийн шаардлагын дагуу "магадлал бүхий шалтгаан"-ы стандарт хэм хэмжээг хангасан байх ёстой. "Магадлал бүхий шалтгаан" гэж "контрабанд эсвэл гэмт хэргийн нотлох баримтыг тухайн тодорхой газраас олж болох үнэн магадлалтай байхыг" хэлнэ гэж тайлбарласан байна.²⁶ Зөвшөөрөл авах тухай мэдүүлэгт хайж буй нотлох баримт нь гэмт хэрэг үйлдсэн буюу контрабандыг илрүүлэх, гэмт хэргээр олсон үр ашиг эсвэл гэмт хэргийн улмаас бий болсон эд хөрөнгийн нотлох баримтыг бүрдүүлж буйд итгүүлэхүйц "магадлал бүхий шалтгаан"-ыг тогтооход хангалттай мэдээллийг багтаасан байвал зохино. Хайлт хийх зөвшөөрөл авах тухай мэдүүлэгт уг хайж буй нотлох баримтыг тодорхой байршлаас, хурааж авах тодорхой эд зүйлс, тэдгээрийг таниулахуйц

²⁶ *Illinois v. Gates*, 462 U.S. 213, 238 (1983).

хангалттай нарийвчлалтай дэлгэрэнгүй танилцуулгын хамт олж авч чадна гэдэгт итгэх үндэслэлтэй учир шалтгааныг мөн оруулах хэрэгтэй.

4. Шүүхийн шийдвэрийн агуулга хэлбэр

Шүүхийн шийдвэр нь бичгэн хэлбэртэй байх бөгөөд дараах зүйлсийг агуулсан байна. Үүнд:

- Шүүх эрх мэдлийн байгууллагын нэр, маргаан шийдвэрлэгч этгээдийг тодорхойлох ба шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон хугацаа
- Шүүхийн шийдвэрт аль хуулийг хэрэглэж байгаа
- Хайлт хийхэд хэрэглэгдсэн арга зүй
- Зөвшөөрөл олгосон хүрээ, хугацаа
- Харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдлийн суурь мэдээлэл

Харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдөлд урьд өмнө байгаагүй шинэ буюу өвөрмөц, эсвэл эрх зүйн асуудал орсон байвал шүүгч нь шүүхийн захирамж гаргах шүүгчийн шийдвэрийн үндэслэл, асуудлын талаар тайлбарлан бичгээр дүгнэлт гаргана

Холбогдох зарчим (ууд): Тохирохуйц байх, Нийцэхүйц байх, Зохих ёсны ажиллагаа

Олон нийтийн хяналт тавих хариуцлагатай үйл явцыг хөнгөвчлөхийн тулд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах бүх шүүхийн шийдвэрт шүүхийн шийдвэрлэх үндэслэл болж буй хууль, хуулийн заалтыг ойлгомжтой бичих хэрэгтэй. Энд шүүхийн захирамжийг гаргасан он, сар, өдөр, зөвшөөрөл олгосон шүүгчийн нэр, албан тушаалыг дурдана. Дэмжигдсэн өргөдлийг мөн хавсаргана.

Үүнээс гадна, шүүхийн шийдвэрт харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг яг чухам аль бүртгэл, төхөөрөмж, мэдээлэл агуулагчид явуулах, ялангуяа харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны хамрах хугацаа, хайлт хийх арга зүй, уг ажиллагаанд хэрэглэх хэрэгсэл, аргуудыг багтаасан иж бүрэн хүрээг эрх олгох ажиллагаанд тодорхойлсон байх ёстой. Мөн, шүүхийн шийдвэрт аль болохоор хайлт хийгдэх яг тухайлсан мэдээллийн санг тодорхойлж, наад зах нь хайлт хийх хэрэгцээ шаардлагатай мэдээллийг бүрдүүлж буй файл төрлүүдийг жагсаасан байх шаардлагатай.

Шүүгч харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдлийн нарийвчилсан мэдэгдлүүдэд шүүхийн шийдвэрийн нэр томъёог тохируулах ёстой. Шүүхийн шийдвэр нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг өргөдөлд хүссэнээс илүү өргөжүүлсэн хүрээнд олгож хэзээ ч болохгүй. Шүүгч хэрэгцээ шаардлагатай байгаа мэдээллийг хамгаалагдсан мэдээллээс л зөвхөн олох боломжтой гэдгийг хангалттай нотолсон үед маш нарийн явцуу эрх олгоно.

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах шүүхийн шийдвэр нь хамгаалагдсан мэдээлэл хадгалагдаж болох хугацаанд тодорхой хязгаарлалт тогтоох хэрэгтэй. Иймээс шүүхийн шийдвэрийн дагуу олж авсан бүхий л мэдээллийн талаарх тайлангаар тогтмол хангах хэрэгтэй гэдгийг шүүхийн шийдвэрт дурдана. Тайланд хамгаалагдсан мэдээлэл нь тодорхойлсон хууль ёсны зорилгын хүрээний хэрэгцээ шаардлагатай мэдээлэл биш, эсвэл аливаа хамгаалагдсан мэдээлэл нь шүүхийн шийдвэрийн хүрээнээс гадуур байна гэдгийг тусгана. Үүнээс гадна, шүүхийн шийдвэрийн цар хүрээнд хэрэгцээ шаардлагатай мэдээллээ шүүгчийн тогтоосон хангалттай хугацаагаар зөвхөн хадгалж байж болох ч харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах хууль ёсны зорилгын тогтоол нь илүү урт хугацаанд хүчинтэй байж болохгүй.

Харилцаа холбоог мөрдөн тагнах зөвшөөрөл хүссэн өргөдөлд урьд өмнө байгаагүй шинэ, өвөрмөц эсвэл эрх зүйн хүрээний асуудлууд орсон байвал шүүгч нь шүүхийн захирамж гаргах шүүгчийн шийдвэрийнхээ үндэслэл, асуудлын талаар тайлбарлан бичгээр дүгнэлт гаргана. Бичгэн дүгнэлт нь олон нийтэд нээлттэй байх ёстой.

5. Шүүхийн хяналт

Шүүх эрх мэдлийн байгууллага нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах шүүхийн шийдвэр (эсвэл, шүүхийн шийдвэр хайх буюу олж авах ажиллагаа нь амжилтгүй болсон төрийн агент, зарим бусад шүүгч)-ийн хэрэгжилтэд мониторинг хийх үүрэгтэй. Шүүхийн шийдвэрээр явуулж буй үйл ажиллагааны төрийн тайланг баталгаажуулах ёстой.

Холбогдох зарчим (ууд): Зайлшгүй шаардлагатай байх, Нийцэхүйц байх

Төр нь хайлт хийх явцдаа олж авсан хамгаалагдсан мэдээлэл болон бусад бүх төрлийн мэдээллийн талаар шүүх эрх мэдлийн байгууллагад тайлагнах ёстой. Ингэснээр шүүх эрх мэдлийн байгууллага тухайн төрийн агентыг шүүхийн шийдвэрийн бүх нөхцөл шаардлагыг биелүүлсэн эсэхийг баталгаажуулна.

Төрийн агент нь хэрэгцээ шаардлагатай байгаа бүхий л мэдээллийг тусгайлан авч үзэх ёстой. Төрийн агент хайлт хийх эрхээ хэрэгжүүлэхдээ шүүх эрх мэдлийн байгууллагад тогтмол тайлагнах үүрэгтэй бөгөөд хайлтын үр дүнд олж авсан хамгаалагдсан мэдээллийг төр хадгална. Ингэж тайлагнах хугацаа нь 30-аас доошгүй хоног байх ба илүү халдлагын шинжтэй, өргөн хүрээний хайлт хийж байгаа тохиолдолд мэдээлэх мөчлөгийг богиносгоно. Тайланд хайж буй хэрэгцээ шаардлага бүхий мэдээлэл, тайлант хугацаанд олж авсан хамгаалагдсан мэдээллийн хамрах хүрээ, нэвтрэх болсон үндэслэл шалтгааныг тодорхой дурдвал зохино.

Тайлантай танилцаад шүүхийн эрх мэдлийн байгууллагаас зохисгүй, хууран мэхлэх оролдлого хийсэн гэж нотлогдсоноос бусад хэрэгцээ шаардлагатай гэж тооцогдоогүй хамгаалагдсан мэдээллийг устгах шийдвэр гаргана. Энэ тохиолдолд шүүгч нь хууль зөрчсөн төрийн агентын мөрдөн шалгалтын дор буй мэдээллийг нэн даруй битүүмжлэх арга хэмжээ авах үүрэг өгөх ёстой. Нэгэнт хууль ёсны зорилгод нийцэхгүйг тогтоосноор олж авсан хэрэгцээ шаардлагатай мэдээлэл, мөн бусад бүх хамгаалагдсан мэдээллийг шүүгчийн шийдвэрээр устгуулна.

Тайланд шүүх эрх мэдлийн байгууллагаас хамгаалагдсан мэдээллийг устгахтай холбоотой гаргасан аливаа тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцын талаар заавал тусгана. Төрийн агент шүүх эрх мэдлийн байгууллагад тухайн мэдээллийг устгасан арга хэлбэрийг тодорхой тайлагнах үүрэгтэй. Хэрэв шүүгч мэдээлэл устгалд оруулах үйл явц удаашралтай, саатсан гэж үзвэл учир шалтгааныг олж тогтоох мөрдөн шалгах ажиллагаа явуулах бөгөөд холбогдох захиргааны шийтгэл ногдуулж, шаардлагатай тохиолдолд тайлагнах мөчлөгийг богиносгоно.

6. Мөрдөн шалгах ажиллагаа

Мөрдөн шалгах ажиллагаа шаардлагатай гэж харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах шүүхийн шийдвэр гаргасан шүүгч (эсвэл, шүүхийн шийдвэр хайх буюу олж авах ажиллагаа нь амжилтгүй болсон төрийн агент, зарим бусад шүүгч) мөрдөн шалгах ажиллагааг баталгаажуулахтай холбогдох мэдээллийг шийдвэрлэнэ. Өөр тусгай шүүгч аливаа нэг мөрдөн шалгах ажиллагааг даалгасан, холбогдох мэдээллээс хэтрүүлэн хөрөнгийн хариуцлага ногдуулж болно. Нэгэнт мөрдөн шалгах ажиллагаанд орж дүгнэгдсэн мэдээллийг устгалд оруулна.

Холбогдох зарчим(ууд): Хууль зүйн үндэслэлтэй байх, эрх бүхий шүүхийн байгууллага, зүй ёсны ажиллагаа, хууль бусаар хандахын эсрэг баталгаа

Хувь хүний нууцад хөндлөнгөөс хууль бусаар оролцох нь ардчилсан засаглалын үнэ цэнийг бууруулсан хүний эрхийн зөрчил юм.²⁷ Ердөө багахан хэмжээний хөндлөнгийн оролцоо хүртэл бүхэлд нь авч үзвэл ноцтой зөрчил бий болгодог. Төрийн агентууд харилцаа холбооны мөрдөн тагнах үйл ажиллагааг зохисгүй явуулсан тохиолдолд заавал шүүхийн мөрдөн шалгах ажиллагаанд дуудагддаг байх ёстой. Энэхүү Хэрэгжүүлэх удирдамжид дурдсанаас бусад мөрдөн тагнах ажиллагаа явуулах шаардлагатай гэж үзвэл, шүүгч тухайн агентад харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаатай холбогдох шүүхийн шийдвэр зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд аливаа шүүхийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай шийдвэр гаргана. Үүнээс гадна, төрийн агент шүүхийн шийдвэр хамрах хүрээнээс

²⁷ La Rue, *supra* note 2

гадуур үйлдэл хийсэн, эсхүл бусдад ийм үйлдэл хийх заавар өгсөн, тухайн хамгаалагдсан мэдээлэл нь зайлшгүй шаардлага бүхий мэдээлэл агуулаагүйг мэдсэн боловч санаатайгаар нэвтэрсэн, хамгаалагдсан мэдээллийг хууль эрх зүйн баримт бичигт зааснаас бусад зорилгоор ашигласан, шүүхийн эрх бүхий байгууллагаас гаргасан бусад төрлийн нэмэлт зарчим, шаардлагыг зөрчсөн зэрэг нь энэ тохиолдолд мөн адил шүүгч шүүхийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах шийдвэр гаргах үндэслэл болно.

Шүүхийн мөрдөн шалгах ажиллагаа нь нийтэд нээлттэй байх ба хариуцсан шүүгчийг томилохдоо харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаатай холбогдсон шүүхийн шийдвэр гаргасан шүүгчийг томилохгүй. Мөрдөн тагнах ажиллагаа гүйцэтгэх шаардлагатай аливаа нөхцөлд тус нөхцлийг бүрдүүлсэн аливаа мэдээллийг бусад олж авсан мэдээллээс тусгаарлан битүүмжилсэн байна. Мөрдөн шалгах ажиллагааны үеэр битүүмжлэлтэй мэдээллийн нууцлалыг хадгалах хариуцлагыг шүүгч хүлээнэ. Битүүмжлэлтэй мэдээллийг мөрдөн шалгах ажиллагаанаас бусад зорилгоор ашиглахыг хатуу хориглоно. Мөрдөн шалгах ажиллагаа дуусмагц, шүүгч бүх мэдээллийг устгуулна.

Аливаа мөрдөн шалгах ажиллагаанд оролцож буй төрийн агентыг шүүх ажиллагаа дуусгавар болох хүртэл аливаа харилцаа холбооны мөрдөн тагнах ажиллагаанд оролцохыг хориглоно. Мөрдөн шалгах ажиллагааг хариуцахаар томилогдсон шүүгч тухайн төрийн агентад үйл ажиллагааг нь түр зогсоох, түдгэлзүүлэх, нөхөн олговор төлүүлэх, нийтэд хүлцэл өчсөн мэдэгдэл хийлгэх, урт хугацааны хяналт тавих, тайлан гаргуулах болон бусад хуулиар олгогдсон захиргааны шийтгэл ногдуулах эрхтэй байна. Шүүхийн мөрдөн шалгах ажиллагааны үед халдлагад өртсөн иргэний зүгээс иргэний арга хэмжээ урьдчилж авахыг хэрхэвч зөвшөөрөхгүй. Хэрэв халдлагад өртсөн хэрэглэгч иргэний арга хэмжээ авах сонголт хийвэл холбогдох мэдээлэл устгагдах хүртэл түүний битүүмжлэлийг алдагдуулахгүй (эрх зүйн хамгаалалт хэсгээс дэлгэрэнгүйг үзнэ үү).

7. Онцгой ажиллагааны журам

Онцгой ажиллагааны нөхцөл шаардлагаар шүүх эрх мэдлийн байгууллага нь онцгой ажиллагааны журмыг хэрэглэхээр шийдсэн тухай мэдэгдлийг үнэлнэ. Мөн үүнд уг мэдэгдэлд шаардлагатай бүх баримт болон онцгой ажиллагааны нөхцөл шаардлагад байгааг тодорхойлоход нь шүүгчид зориулсан мэдэгдэл нотолгоонуудыг хавсаргасныг баталгаажуулна. Жишээлбэл, шүүх эрх мэдлийн байгууллага хайлт хийх ажиллагааг санаачилсны дараа боломжит хугацааны дотор харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасныг баталгаажуулах бөгөөд маш богино хугацаанд өргөдлийг хянаж үзэх ёстой. Онцгой ажиллагаа явуулах үндэслэлийг бие даан хянан үзвэл зохино.

Холбогдох зарчим(ууд): Хууль зүйн үндэслэлтэй байх, эрх бүхий шүүхийн байгууллага, зүй ёсны ажиллагаа, хууль бусаар хандахын эсрэг баталгаа

Төрийн агентаас шүүх эрх мэдлийн байгууллага онцгой ажиллагаа явуулах хүсэлтээ ирүүлсэн тохиолдолд, тухайн шүүх эрх мэдлийн байгууллага мэдэгдлийг хүлээн авч, нэн даруй шүүгчид шилжүүлсэн байна. Шүүгч хүсэлтийг хянаж үзээд хайлт хийх зөвшөөрөл хүссэн өргөдөл нь бүрэн гүйцэд, холбогдох хууль тогтоомжид нийцсэн, мөн үргэлжлэх хугацаа нь хүлээн зөвшөөрөхүйц байгаа эсэхийг нягтлан баталгаажуулна. Хайлт хийхийг хүлээн зөвшөөрөхүйц үргэлжлэх хугацаа нь 24-72 цагаас илүүгүй байна.

Шүүгч онцгой ажиллагаа явуулах хүсэлт, харилцаа холбооны мөрдөн тагнах ажиллагаа зөвшөөрөл хүссэн өргөдлийн агуулга ба бүрдүүлбэрийг түргэвчилсэн хуваарийн дагуу хянаж үзнэ.²⁸ Шүүгч харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай зөвшөөрөл хүссэн өргөдлийг үл зөвшөөрөх тохиолдолд хайлт хийхийг нэн даруй зогсоож, бүх хамгаалагдсан мэдээллийг нэн даруй устгасан байна. Харин төрийн агентаас зохисгүй, хууран мэхлэх оролдлого хийсэн гэж нотолсон тохиолдолд мөрдөн тагнах ажиллагааг дуусгавар болох хүртэл мэдээллийг битүүмжилнэ. Гаргасан өргөдөл нь агуулга болон хэлбэрийн хувьд дутуу дулимаг, шахалт үзүүлсэн, хэт түрэмгий байх тохиолдолд хүсэлт гаргасан төрийн агентад захиргааны шийтгэл ногдуулах, хориг арга хэмжээ авна.

Шүүгч онцгой ажиллагаа явуулах хүсэлтийг хүлээн зөвшөөрч, өргөдлийг хүлээн авсан боловч өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд тухайн өөрчилсөн шаардлагуудтай уялдуулан хайлт хийхэд нэн даруй тохиргоо хийх бөгөөд, оруулсан өөрчлөлтөөс үүдэн шүүхийн шийдвэрт тусгагдаагүй хамгаалагдсан мэдээллийг нэн даруй устгана. Харин төрийн агентаас зохисгүй, хууран мэхлэх оролдлого хийсэн хэмээн нотолсон тохиолдолд шүүхийн мөрдөн тагнах ажиллагааг дуусгавар болох хүртэл мэдээллийг битүүмжилнэ.

Хэрэв өргөдлийг хүлээн авсан боловч шүүгч хянаж үзээд онцгой ажиллагаа явуулах хууль эрх зүйн үндэслэл байхгүй болохыг тогтоосон, бусад шалтгааны улмаас онцгой ажиллагааг буруу явуулсан, эсвэл төрийн агент хангалттай нотолгоо гаргаж чадаагүй зэрэг тохиолдолд хайлт хийхийг үргэлжлүүлэн явуулж болно. Гэсэн хэдий ч шүүгч төрийн агентыг хамгаалагдсан мэдээллийг бие даасан эх сурвалжаас хуулийн дагуу авсан гэсэн нотолгоог шүүгч хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд, шүүхийн шийдвэр гарахаас өмнө хайлт хийгдсэн хамгаалагдсан мэдээллийг нэн даруй устгах ёстой.²⁹

²⁸ [28] An example of adequate justification for the use of emergency procedures would be collecting location data to find a stolen car with a child locked inside. *TELUS Transparency Report 2013*, TELUS, 2013, available at <http://about.telus.com/servlet/JiveServlet/previewBody/5544-102-1-6081/TELUS%20Transparency%20Report%202013%20-English.pdf>

²⁹ See *Murray v. United States*, 487 U.S. 583 (1988).

Хэрэгжүүлж буй жишээ:

Энэтхэгийн Цахилгаан холбооны тухай хуулиар хайлтын ажиллагаагаар ажлын долоон хоногийн дотор нотолбол яаралтай цуглуулах ажиллагааг хүлээн зөвшөөрдөг. Нотолж чадахгүй бол хайлтын ажиллагааг зогсоож, цаашдын цуглуулах ажиллагааг зөвхөн урьдчилан зөвшөөрөл авсан тохиолдолд явуулж болно. Хяналтын хорооноос хайлтын ажиллагааг хуулийн дагуу явагдсан эсэхийг тогтооно. Хэрэв хууль бус бол хороо хайлт хийх ажиллагааг дуусгавар болгон, цугларсан мэдээллийг устгах шийдвэр гаргаж болно.³⁰

³⁰ [30] *Law Enforcement Disclosure Report*, Vodafone, 42 (Jun. 2014), http://www.vodafone.com/content/dam/sustainability/2014/pdf/operating-responsibly/vodafone_law_enforcement_disclosure_report.pdf.

Хайлт хийх

1. Хайлтын хамрах хүрээ

Хайлтыг шүүхийн тогтоолын дагуу гүйцэтгэх ёстой бөгөөд үйлчилгээ үзүүлэгчийн ажиллагааны бүрэн бүтэн байдалд хөндлөнгөөс нөлөөлөх ёсгүй.

Холбогдох зарчим(ууд): Харилцаа холбоо болон сүлжээний шаардлагатай байх, дүйцэхүйц, нийцэхүйц, халдашгүй бүрэн бүтэн байдал

Хайлт хийхдээ харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай шүүхийн тогтоолын хамрах хүрээгээр нарийн хязгаарлагдах ёстой. Онцгой арга хэмжээ авах тохиолдолд, харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай холбогдох хүсэлтэд шүүхийн эрх бүхий байгууллагын шийдвэр гарахаас өмнө онцгой арга хэмжээ авах тухай санаа зорилгоо мэдэгдэх зохистой хугацаагаар хязгаарлагдах ёстой. Төрийн аливаа агентын хувьд хайлт хийхэд чиглэсэн этгээдэд хамааралгүй төхөөрөмж, бүртгэл, санд нэвтрэхийн тулд бүтцийн дахин тохиргоо хийх, код, нууц үг эвдэх, мэдээллийн бусад хэсгийг өөрчлөхийн тулд үйлчилгээ үзүүлэгчийг татан оролцуулж буй үйл ажиллагаа нь шүүхийн тогтоолоос гадуурх үйлдэлд тооцогдоно.

Хэрэгжүүлж буй жишээ:

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 17 дугаар зүйл дэх “үндэслэлтэй байх” гэдэг ухагдахууныг Хүний эрхийн хорооноос “халдашгүй байдалд хөндлөнгөөс оролцох нь ямар ч тохиолдолд дүйцэхүйц болон шаардлагатай байх зорилгод нийцсэн байх ёстой”³¹ хэмээн тайлбарласан.

2. Зардал

Хайлт хийх ажиллагаатай холбогдох зардлыг төр хариуцах үүрэгтэй.

Холбогдох зарчим(ууд): Хууль бус хандалтын эсрэг баталгаа

Төр нь хайлт хийх ажиллагаа явуулахад гарах зохих зардлыг үйлчилгээ үзүүлэгчид нөхөн олгох үүрэгтэй. Бүхий л зардлын үндэс нь хуулиар тогтоогдсон байх шаардлагатай. Үйлчилгээ үзүүлэгч нь хуулинд заагдсан, харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулахад санхүүгийн аливаа гажуудал үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд шүүхийн эрх бүхий байгууллагаас тогтоосон зохистой зардлаас илүү буюу нэмэлт төлбөрийн асуудлаар төртэй гэрээ байгуулахыг зөвшөөрөхгүй.

¹ [31] UN Human Rights Committee, *supra* note 17, at para 8.3.

Нөхөн төлбөрийг боломжит хугацаанд, зардал гарсан өдрөөс эхлэн 30 хоногоос хэтрэхгүй хугацаанд олговол зохино.

Хэрэгжүүлж буй жишээ:

Швейцарь улсад Холбооны засгийн газар нь мөрдөн тагнах хүсэлт гүйцэлдүүлэхэд гарсан зардлыг нөхөн олгохыг шаарддаг. Засгийн газар нь мөрдөн тагнах ажиллагааны төрөлд³² үндэслэн нөхөн төлбөрийн бүдүүвчийг баримталдаг.

3. Хайлт хийх тухай хүсэлт гаргах

Үйлчилгээ үзүүлэгчдэд хандаж хайлт хийх тухай хүсэлт гаргахдаа бичгээр үйлдэх шаардлагатай бөгөөд төрийн зүгээс үйлчилгээ үзүүлэгчид дамжуулахыг хүсч буй хэрэглэгчийн өгөгдөл, уг хүсэлтийн хуулийн үндэслэл, хайлт хийх хүсэлт гаргасан төрийн агент болон хайлт хийх эрх олгогч шүүхийн эрх бүхий байгууллагын нэр, харилцаа холбоог тодорхой тусгаж, шүүхийн тогтоолын дагуу шаардагдаж буй хэрэглэгчийн өгөгдлийг хэрхэн хайх талаар товч дурдсан байвал зохино. Зөвшөөрөгдсөн хайлтын хамрах хүрээг ойлгоход шаардагдах аливаа баримт бичгийг хайлт хийх тухай хүсэлттэй хавсаргах нь зүйтэй.

Холбогдох зарчим(ууд): Зохих ёсны үйл ажиллагаа ба олон нийтийн хяналт

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай шүүхийн тогтоол нь хайлт хийх тухай хүсэлтийг шүүхийн захирамжид дурдсан үйлчилгээ үзүүлэгчдээс шалтгаалан нэгээс илүү хувь үйлдэж болно. Хайлт хийх тухай хүсэлт нь тухайлсан үйлчилгээ үзүүлэгчид нарийн тохируулсан байх ёстой. Үйлчилгээ үзүүлэгчид дор дурдсан нөхцөлд хайлт хийх тухай хүсэлтийг хүлээн авах нь зүйтэй. Үүнд:

- Бичгээр үйлдсэн
- Хүсэлтийн хууль зүйн үндэслэлийг тайлбарласан
- Хүсэлт гаргаж буй албан тушаалтны нэр, эрхэлсэн ажил тодорхой байх
- Хайлтын зөвшөөрөгдсөн хамрах хүрээ, үргэлжлэх хугацаа, аргачлалыг тодорхой заасан
- Эрх зүйн болон зохицуулалтын бүхий л холбогдох шаардлагад нийцсэн байх.

Хайлт хийх тухай аливаа хүсэлтэд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай шүүхийн холбогдох тогтоол болон уг ажиллагаа явуулах тухай өргөдөл, мөн түүнчлэн хайлт хийх тухай хүсэлтийн хамрах хүрээг үйлчилгээ үзүүлэгчдэд ойлгуулахад шаардагдах бусад баримт бичгийг иж бүрэн хавсаргавал зохино.

³² [32] Захидал, харилцаа холбоог хянах ажиллагаанд төлбөр, нөхөн олговор олгох тухай зохицуулалт, SR 780.115.1, April 7, 2004, <http://www.admin.ch/opc/de/classified-compilation/20032564/index.html>

4. Хэрэглэгчдэд мэдэгдэх

Төрийн агент харилцаа холбоог мөрдөн тагнах эрх бүхий ажиллагааны зорилгод учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд хойшлуулах онц чухал шаардлагатай гэдэг үндэслэлийг шүүхийн эрх бүхий байгууллагад илтгэх боломжгүй бол хайлт хийхээс өмнө чиглэсэн этгээдэд мэдэгдэнэ. Мэдэгдэл хүргүүлэх үүрэг төрд ноогдоно.

Холбогдох зарчим(ууд): Хэрэглэгчдэд мэдэгдэх

Төр нь чиглэсэн этгээдэд хайлт хийх үндэслэлийг шаардах, хайгдаж буй мэдээлэлд холбогдох аливаа эрхийг хамгаалахад зохих боломж олгох зорилгоор түүнд харилцаа холбоог мөрдөн тагнах тухай шүүхийн тогтоолын талаар мэдэгдэх ёстой.

Хэрэв чиглэсэн этгээд шүүхийн тогтоолын үндэслэл, хайлтын хамрах хүрээ, түүнчлэн шүүхийн тогтоолыг, харилцаа холбоог мөрдөн тагнах тухай шүүхийн эрх бүхий байгууллагын албан бичиг зэргийг шаардахаар бол мэдэгдэлд эрх зүйн зөвлөгөө авах боломжоор хангахуйц мэдээлэл агуулагдах шаардлагатай.

Хязгаарлагдмал тохиолдолд төрийн агентын хүсэлтийн дагуу мэдэгдэл хүргэх ажиллагааг зохих хугацаанд хойшлуулж болох бөгөөд үүнийг шүүхийн эрх бүхий байгууллагаас баталгаажуулна. Хугацаа хойшлуулсан мэдэгдлийг баталгаажуулах хүсэлтийг сайтар нягтлан үзэх шаардлагатай бөгөөд хэзээ ч автоматаар хийж болохгүй. Ингэхийн оронд, төрийн агент харилцаа холбоог мөрдөн тагнах эрх олгогдсон зорилгод учирч болзошгүй ноцтой аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор зайлшгүй хийгдсэн гэдгийг илтгэсэн тохиолдолд мэдэгдэл хойшлуулахыг зөвшөөрнө.³³

Үүнийг авч үзэхийн тулд дараах хүчин зүйлийг харгалзах шаардлагатай.

- Аливаа хувь хүний амь нас, бие махбодид бодитой аюул занал учруулах
- Мөрдөн байцаалтаас зугатах
- Хуурамч үйлдлийн нотолгоо гаргах
- Гэрчийг сүрдүүлэх зэрэг

Сайтар тодорхойлогдсон, тохиромжтой цаг хугацааны хүрээнд, ерөнхийдөө 30 хоногоос хэтрээгүй хүсэлтэд гагцхүү зөвшөөрөл олговол зохино. Хэрэв хүсэлтийг товлогдсон хугацаанаас хэтрүүлэх шаардлага гарвал, төрийн агент доорх баримтыг шүүхийн эрх бүхий байгууллагад гарган өгч, хугацаа хойшлуулахаар хүсэлт гаргана.

³³ [33] See, e.g. *Klass v. Germany*, App. No. 5029/71, 2 Eur. H.R.Rep. 214 (1978).

- Төрийн агент нь харилцаа холбоонд мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай шүүхийн захирамжид заагдсан бүхий л шаардлагыг хангасан байх
- Заагдсан хугацаанд шаардлагатай мэдээллийг цуглуулах тал дээр хүчин чармайлт гаргасан байх
- Мэдэгдэл хойшлуулахад нөлөөлсөн нөхцөл байдлыг тогтоосон байх
- Цаашид сунгах хэрэгцээ шаардлагыг илэрхийлсэн байх

Хугацааг дахин хойшлуулах бол үүнийг эхнийхтэй адилтган үзэх ёстой бөгөөд ижил цаг хугацааны хязгаарлалт тавина. Хойшлуулах хугацаа тодорхой байх ёстой. Чиглэсэн этгээдэд хойшлуулсан үндэслэлийн хугацаа дуусмагц аль болох түргэн мэдэгдэнэ.

Төрийн зүгээс гаргасан мэдэгдэл өгөхөөс гадна, үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчдэдээ харилцаа холбоог мөрдөн тагнах тухай шүүхийн тогтоолын талаар мэдээлэх үүрэгтэй.³⁴

Хэрэгжүүлж буй жишээ:

Япон улсад, Харилцаа холбоог олзлох тухай хуулийн дагуу харилцаа холбоогоо дундаас нь бариулсан этгээдэд энэ талаар мөрдөн тагнах ажиллагаа дууссаны дараа 30 хоногийн дотор мэдэгдэл өгөх үүрэгтэй. Явагдаж буй мөрдөн шалгалт ийм төрлийн мэдэгдлийг хамарч байвал, тойргийн шүүхийн шүүгч хугацааг тухайн субьектэд мэдэгдэх боломжтойгоор сунгаж болно.

5. Үйлчилгээ үзүүлэгчийн хариу үйлдэл ба асуудал бэрхшээл

Гагцхүү хүчин төгөлдөр шүүхийн тогтоолд үндэслэсэн хайлт хийх тухай хүсэлтэд үйлчилгээ үзүүлэгч хамгаалагдсан мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй. Хайлт хийх тухай хүсэлт эдгээр зарчмууд, хүний эрхийн олон улсын үүрэгтэй нийцэхгүй бол үйлчилгээ үзүүлэгч нь дэлгэрэнгүй тайлбарыг шаардах, мөн зохистой нөхцөлд хүсэлтийн хууль зүйн үндэслэлийг шаардах нь зүйтэй.

Холбогдох зарчим(ууд): Хууль зүйн үндэслэлтэй, хууль ёсны зорилготой, шаардлагатай, нийцэхүйц, дүйцэхүйц байх, шүүхийн эрх бүхий байгууллага, зохих ёсны ажиллагаа

Үйлчилгээ үзүүлэгч нь хайлт хийх тухай хүсэлт хүлээн авсаны дараа зөвхөн хамгаалагдсан мэдээллийг түүний хамгийн хязгаарлагдмал бүтцийн дагуу төрд

³⁴ [34] Хэрэглэгчийн өгөгдөлд компаний гүйцэтгэх үүргийн талаар цаашид хэлэлцэх болно.

гаргаж өгөх нь зүйтэй.³⁵ Аливаа тодорхойгүй байдал чиглэсэн этгээдийн талд шийдвэрлэгдэх ёстой. Төр болон үйлчилгээ үзүүлэгчийн хооронд аливаа асуудлаар зөрчилдөөн үүсэх аваас шүүхийн эрх бүхий байгууллага маргааныг тасалж, харилцаа холбоог мөрдөн тагнах тухай шүүхийн тогтоол, хайлт хийх тухай хүсэлтэд тодруулга хийнэ.

Хэрэв хайлт хийх хүсэлт нь хуулийн дагуу бус, эсвэл энэхүү хэрэгжилтийн удирдамжтай зөрчилдвөл үйлчилгээ үзүүлэгч хамгаалагдсан ямар ч мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзах, мөн түүнчлэн хайлт хийх хүсэлтийн эсрэг хэрэг үүсгүүлэхээр хуулийн байгууллагад өргөдөл гаргах нь зүйтэй.³⁶ Хайлт хийх хүсэлт нь дотоодын хуулинд нийцээгүй боловч хүний эрхийн олон улсын хуулинд нийцсэн, эсвэл улс төрийн үймээн самууны үед үйлдэгдсэн тохиолдолд, үйлчилгээ үзүүлэгч хүний эрхэнд учрах эрсдэл, мөн эрх зүйн болон үйл ажиллагааны эрсдэлийг тооцох ёстой. Түүнчлэн ганц талын буюу олон талт нөлөөлөл, маргаан хэлэлцээр, шууд эсэргүүцлийн замаар хайлт хийх тухай аливаа хүсэлтээс зайлсхийх, хариуг хязгаарлах шаардлагатай.

Үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагаа явуулж буй, явуулахаар төлөвлөж буй нөхцөл бүрт хүний эрхийн нөхцөл байдлыг үнэлэх нь зүйтэй. Уг үнэлгээний нэг хэсэг болгож, үйлчилгээ үзүүлэгч дотоодын болон олон улсын холбогдох талууд, хүний эрхийн хараат бус шинжээчид, дотоодын холбогдох хуулиуд, зохицуулалтын шаардлагуудын талаар тодорхой ойлголт бүхий дотоод, гадаадын зөвлөхүүдтэй хамтран ажиллах шаардлагатай. Үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчийн хандалт, мөн хүний эрхийг олон улсын хүний эрхийн хууль, эрх зүйн хэм хэмжээнд нийцэхгүй илэрхий хязгаарласан үйл ажиллагааны орчинд ажиллахаас зайлсхийвэл зохино. Үйлчилгээ үзүүлэгч хүний эрхтэй холбогдох эрсдэлд зохих ёсны шалгалт хийж, тодорхой орчинд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд зохимжтой эсэхийг анхаарах нь зүйтэй.

Хэрэгжилтийн жишээ:

Access байгууллагаас гаргасан Үйл ажиллагааны Telco төлөвлөгөөнд туссан харилцаа холбоо, интернэт үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан 10 зарчим, түүний хэрэгжилтийн удирдлага нь хүний эрхэд үзүүлэх аливаа сөрөг нөлөөг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилготой.³⁷ Уг төлөвлөгөө нь үйлчилгээ үзүүлэгчдэд “Засгийн газар, бусад хамтрагчдаас гаргасан хэрэглэгчийн хандалт,

³⁵ [35] Үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчийн өгөгдлийг хамгаалах үүрэгтэй. Хэрэв хайлт хийх тухай хүсэлт энэхүү хандлагагыг няцааж, гагцхүү хамгаалалтгүй мэдээлэлд хамаарах бол үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн эрх ашигт нийцүүлэн, энэхүү хэрэгжилтийн удирдамжид заагдсан хамгаалалтуудыг харгалзан ажиллах нь зүйтэй.

³⁶ [36] Энэ хэсэг нь харилцаа холбооны компаниудад хүний эрхийг хүндэтгэн сахих уай нарийвчилсан заавар бүхий Үйл ажиллагааны Access Telco төлөвлөгөөтэй холбогдоно.

³⁷ [37] Access, Үйл ажиллагааны *Telco төлөвлөгөө*,

https://s3.amazonaws.com/access.3cdn.net/1f9ab2891a86f3f081_uom6iil1w.pdf

үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, халдашгүй байдлыг хязгаарлах тухай хүсэлтээс аль болох татгалзах нь зүйтэй” хэмээн зөвлөж байна. Үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчийн эрхэнд халдаж болзошгүй хүсэлтээс татгалзахдаа “Ганц талын болон олон талт яриа хэлэлцээнд оролцох, засгийн газар, бизнесийн түншүүдэд шаардлагатай тохиолдолд нөлөөлөл хийх” нь зүйтэй. Тодорхой хүсэлтийг сөрөхдөө ижил төстэй компаниудтай хамтрах нь үйлчилгээ үзүүлэгчдэд засгийн газрын хүний эрхэнд аюул занал учруулахуйц шаардлагаас татгалзахад амжилт гаргах боломж олгоно.³⁸

Хэрэгжүүлж буй жишээ:

Хүний эрхийн өмнө хүлээсэн олон улсын гэрээний үүргийг компаниудад шууд ноогдуулахын оронд төрд хариуцуулах нь зүйтэй. Гэсэн хэдий ч үйлчилгээ үзүүлэгчид хүний эрхийг хүндэтгэн сахих хариуцлага хүлээнэ.³⁹ НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмын дагуу тайлбарласнаар:

Хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг хариуцлага нь аль ч газар үйл ажиллагаа явуулж буй бизнесийн бүхий л байгууллагын хувьд мөрдөх дэлхий нийтийн хэм хэмжээ юм. Энэ нь тухайн улсын хүний эрхийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх чадамж, хүсэл эрмэлзлээс үл хамааран үйлчилнэ. Мөн түүнчлэн хүний эрхийг хамгаалсан үндэсний хууль тогтоомж, зохицуулалтаас дээгүүр байна.⁴⁰

Бизнес ба хүний эрхийн удирдах зарчимд бизнесийн хариуцлага, түүний дотор зохих ёсны хичээл зүтгэл гаргах, арга хэрэгслийн үр нөлөөтэй хүртээмжээр хангах зэрэг бизнесийн мөн чанарыг гаргасан.

6. Өгөгдлийн засаглал

Үйлчилгээ үзүүлэгчид нь өгөгдлийн аюулгүй байдлын цэвэр байдлыг ашиглах шаардлагатай бөгөөд сүлжээндээ мөрдөн хянах болон мониторингийн арга хэрэгслийг нэвтрүүлэх ёсгүй.

Холбогдох зарчим(ууд): Харилцаа холбоо болон сүлжээний халдашгүй бүрэн бүтэн, ил тод байдал

Үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчдэдээ ашиглалтын горим, хувийн нууцын талаарх бодлого, хэрэглэгчийн удирдлагын бусад хэлбэр, хэрэглэгчийн эрхийн

³⁸ [38] Access, “Update: SMS finally unblocked in Central African Republic,” 25 July 2014, <https://www.accessnow.org/blog/2014/07/25/update-sms-finally-unblocked-in-central-african-republic>.

³⁹ [39] See Joseph, Sarah and Castan, Melissa (2013), *The International Covenant on Civil and Political Rights: Cases, Materials, and Commentary 3rd ed*, p541.

⁴⁰ [40] *Guiding Principles on Business and Human Rights: Implementing the Protect, Respect, and Remedy Framework*, (2011), HR/ PUB/11/04, p13.

хязгаарлалтын талаар ил тод мэдээлэх ёстой. Энэ төрлийн мэдээлэл нь үнэн зөв, тодорхой, хүртээмжтэй үг хэллэг ашиглах бөгөөд улс орон болон хүсэлт гаргаж буй аж ахуйн нэгжийн дагуу ангилагдсан байвал зохино.

Улс орнуудын хэрэглэгчийн өгөгдөлд нэвтрэх онцгой аргыг энэхүү хэрэгжилтийн удирдамжид тусгагдсан үйл явцын дагуу хангахын тулд, үйлчилгээ үзүүлэгчид өгөгдлийн аюулгүй байдлын ач холбогдол бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй. Эхийн ээлжинд үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчийн өгөгдлийг цуглуулахдаа бизнесийн ердийн хамрах хүрээний хэрэгцээнээс хэтрүүлэх ёсгүй. Үүнээс гадна, үйлчилгээ үзүүлэгч өөрийн хадгалж буй хэрэглэгчийн өгөгдлийг хамгаалахад чухал алхам хийх, тэр дундаа өгөгдлийн санд хадгалагдаж буй өгөгдөл, мөн түүнчлэн бусад хэрэглэгчид, компани, дотоод сүлжээнд дамжуулж буй, эсвэл тэднээс ирсэн өгөгдөл зэргийг хамгаалах алхам хийх нь зүйтэй.

Өгөгдлийн аюулгүй байдлыг үргэлж хангасан байх ба аливаа шинэчлэлийг хэрэглэгчдэд хүргэхдээ тогтсон бодлого, хандалтад тавих хяналтыг өөрчлөх ёсгүй. Боломжтой нөхцөлд үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчдэд өөрийн өгөгдлийг үйлчилгээ үзүүлэгчийн хандалтгүйгээр хянах боломжоор хангавал зохино. Хэрэглэгчийн өгөгдлийг бизнесийн ердийн хамрах хүрээний дагуу үйлчилгээ үзүүлэгчид хэрэгцээтэйгээс илүү хугацаагаар хадгалах шаардлагагүй. Үйлчилгээ үзүүлэгчид цаг ямагт аюулгүй байдлын сайн туршлагыг хэрэглэх шаардлагатай бөгөөд аюулгүй байдалд хэм хэмжээ, сүлжээ, технологи нь орчин үеийн байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж байх нь зүйтэй.

Хэрэглэгчийн өгөгдөл дахин хэрэгцээгүй болсон тохиолдолд, түүнийг яаралтай, үйлчилгээ үзүүлэгчийн систем, мөн түүнчлэн хуваалцсан аливаа гуравдагч талын системээс аль алианаас нь бүрмөсөн устгах шаардлагатай. Хэрэглэгчийн өгөгдлийг гуравдагч талтай гагцхүү хүчин төгөлдөр, хууль ёсны гэрээний үндсэн дээр хуваалцана. Үйлчилгээ үзүүлэгчид сүлжээгээ мөрдөн тагнах, түүнд мониторингийн хэрэгсэл нэвтрүүлэх, төрийн мөрдөн тагнах ажиллагаа явуулах зорилгоор хэрэглэгчийн өгөгдөл цуглуулах, хадгалах ёсгүй.

7. Үйлчилгээ үзүүлэгчийн ил тод байдал

Үйлчилгээ үзүүлэгчид хайлт хийх тухай хүсэлттэй нийцүүлэн нарийн тоо баримт бодлогыг ил тодорхой болгох чадвартай байх бөгөөд үүнийг гүйцэлдүүлвэл зохино. Үйлчилгээ үзүүлэгчид боломжтой нөхцөлд хэрэглэгчдэд тэдний өгөгдөлд хандаж буй талаар мэдэгдэх үүрэгтэй.

Холбогдох зарчим(ууд): Хэрэглэгчийн мэдэгдэл ба ил тод байдал

Үйлчилгээ үзүүлэгчид хайлт хийх тухай хүсэлтийн хариуг баримтжуулан, ил

тодорхой болгож, эдгээр хариуг тогтмол хянах хэрэгтэй. Үйлчилгээ үзүүлэгчдийн ил тод байдлын тайланд дараах зүйлсийг тусгасан байвал зохино:

- Хууль эрхийн актаар төрөлжүүлсэн хүсэлтийн хэлбэр бүрийн нийт тоо, мөн түүнчлэн яаралтай ажиллагаа шаардсан хүсэлтийн нийт тоо
- Хайгдаж буй мэдээллийн төрлийн нийт тоо
- Чиглэсэн хэрэглэгчид болон бүртгэл дансны нийт тоо
- Өртсөн хэрэглэгчид болон бүртгэл дансны нийт тоо
- Мэдэгдлийг хойшлуулах тухай хүсэлтэд заагдсан нийт цаг, үүнээс хангагдсан нийт цаг, хойшлуулах хугацааг сунгасан нийт цаг
- Хүлээн авсан хүсэлтийн нийт хувь болон үүнээс хангагдсан хүсэлтийн нийт хувийг харьцуулсан үзүүлэлт
- Хүлээн авсан хүсэлтийн нийт хувь болон үүнээс эрх зүйн бэрхшээлтэй тулгарсан хүсэлтийн нийт хувийн эрх зүйн бэрхшээлийн үзүүлэлт
- Төрөөс үйлчилгээ үзүүлэгчид олгосон нөхөн төлбөрийн нийт хэмжээ.⁴¹

Эдгээр төрлийн мэдээллээр хангах нь хууль бусд тооцогддог улс оронд үйлчилгээ үзүүлэгчид ил тод байдлын тайлан гаргах боломж дээр идэвхтэй ажиллах хэрэгтэй.

Хэрэгжилтийн жишээ:

АНУ-ын Үндэсний аюулгүй байдлыг агентлаг (NSA)-ийн PRISM программ хангамжид оролцогч Гүүгл, Фейсбүүк, Yahoo, Майкрософт зэрэг үйлчилгээ үзүүлэгчид тогтмол ил тод тайлагнадаг. 2013 онд эдгээр компаниуд АНУ-ын Гадаад тагнуулын мөрдөн шалгах шүүхэд тэдний төрийн мөрдөн тагнах үйл ажиллагаанд оролцсон талаарх илүү нарийвчилсан мэдээ тайлагнахад саад болсон журмаас чөлөөлөх талаар нэхэмжлэл гаргасан байдаг.⁴² Эцэст нь тэд Хуулийн Департаменттай шүүхээс гадуур зөвшилцөлд хүрсэн⁴³ боловч Твиттерийн зүгээс өнөөгийн хэмжүүр нь үг хэлэх эрхийг зөрчсөн хэмээн санал зөрөлдсөн байна.⁴⁴

АНУ-ын гадна, Telstra,⁴⁵ TeliaSonera,⁴⁶ болон Deutsche Telekom⁴⁷ зэрэг харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч олон компаниуд ил тод байдлын тайлан гаргах

⁴¹ [41] "We need to know" эвсэлд оролцогч иргэний нийгмийн бүлгүүд, хөрөнгө оруулагчид, худалдааны холбоонууд нь зохицуулалтууд компаниудад хүлээн авсан хүсэлт, өртөгдсөн хэрэглэгчид, данс бүртгэл, төхөөрөмж, агуулах, оролцогч эрх бүхий этгээдийн тодорхой тоог мэдээлэх боломж олгох асуудлыг хүлээн зөвшөөрсөн. Access, "We need to know: companies, civil society call for transparency on surveillance," July 18, 2013

⁴² [42] Sam Gustin, *Tech Titans Press Feds in Battle Over NSA Transparency*, Time, Sept. 10, 2013, <http://business.time.com/2013/09/10/tech-titans-press-feds-in-battle-over-nsa-transparency/>

⁴³ [43] Office of Deputy Attorney General, Letter to General Counsels, Department of Justice, Jan. 27, 2014, <http://www.justice.gov/iso/opa/resources/366201412716018407143.pdf>.

⁴⁴ [44] Jack Linshi, Twitter Pushing DOJ, FBI To Let It Disclose More Info on National Security Requests, Time, July 31, 2014, <http://time.com/3063761/twitter-transparency-report/>.

⁴⁵ [45] Telstra Transparency Report, Telstra, March 2014, http://exchange.telstra.com.au/wp-content/uploads/2014/03/Transparency-Report_2014.pdf.

⁴⁶ [46] [TeliaSonera Transparency Report, TeliaSonera, Aug. 2014, http://www.teliaSonera.com/en/sustainability/transparency-report](http://www.teliaSonera.com/en/sustainability/transparency-report).

⁴⁷ [47] Deutsche Telekom, <http://www.telekom.com/sicherheitsbehoerden>.

болсон. 2014 оны зургадугаар сард Vodafone компани мөрдөн тагнах ажиллагааны асуудал зохицуулсан хуулиудыг тайлбарлан, ⁴⁸ 29 улс оронд өөрийн бодлого, үйл ажиллагаа, засгийн газраас гаргасан хүсэлтийн тоо баримтыг тайлагнасан “ил тод байдлын нарийвчилсан тайлан” гаргасан байдаг.⁴⁹ Үүнээс гадна, үйлчилгээ үзүүлэгч эрсдэл учрах асуудлыг, тухайлбал үйлчилгээ үзүүлэгч компанийн ажилтан засгийн газрын аюулгүй байдлын агенлагт үйлчилдэг, мөн түүнчлэн засгийн газрууд сүлжээнд шууд нэвтрэх боломжоор хангагдсан байдал нь хэрэглэгчийн хувийн нууц, үзэл бодлын чөлөөт илэрхийлэлд учрах холбогдох эрсдэл бий болгосон байна.

⁴⁸ [48] Peter Micek, *Vodafone reports on law enforcement access to user data, worldwide*, Access, June 6, 2014, <https://www.accessnow.org/blog/2014/06/06/vodafone-reports-on-law-enforcement-access-to-user-data-worldwide>.

⁴⁹ [49] Law Enforcement Disclosure Report, Vodafone, http://www.vodafone.com/content/sustainabilityreport/2014/index/operating_responsibly/privacy_and_security/law_enforcement.html

Давж заалдах гомдол гаргах ба эрх зүйн хамгаалалт

1. Хууль бус хандалтын эсрэг шийтгэл

Хамгаалагдсан мэдээллийг хууль бусаар олж авсны төлөө хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байвал зохино. Төр болон компаниудын зүгээс хэрэглэгчийн хамгаалагдсан мэдээллийг олон улсын болон дотоодын хууль зөрчин олж авсан тохиолдолд тухайн хэрэглэгчид гомдол гаргах механизм болон тохирохуйц эрх зүйн хамгаалалт үзүүлэх шаардлагатай. Хууль бус хандалт нь мэдээлэл хадгалагч хэрэглэгчид хор уршиг учруулна хэмээн тооцогдох ёстой.

Холбогдох зарчим(ууд): Хууль бус хандалтын эсрэг баталгаа

Хууль сахиулах байгууллагын агентлаг, хувь оролцогчийн аль аль нь харилцаа холбоог үндэслэлгүй, шаардлагатай бус, зохисгүй, хуулиас гадуур мөрдөн тагнах оролдлого хийхийг хуулиар хориглосон байвал зохино.⁵⁰ Төрийн аливаа агент ийм төрлийн үйлдэл хийсэн, аль эсвэл бусдыг ийм үйлдэл хийхийг албадсан нь тогтоогдвол түүнд хэрэг үүсгэн шалгана (дээр дурдсан). Хууль бус үйлдлийн шинж чанараас хамаараад ёс бус хайлт хийхэд оролцсон этгээдэд тохирохуйц нэмэлт шийтгэл болох эрүүгийн ял, захиргааны хариуцлагын шийтгэл, аль эсвэл бусад төрлийн шууд торгууль ноогдуулна.⁵¹

Зохих ёсны зөвшөөрөлгүйгээр, дотоодын болон олон улсын хууль, дүрэм журам зөрчин олж авсан мэдээллийг эзэмшиж буй хэрэглэгч нь хохирлоо нөхөн төлүүлэх боломжоор хангагдсан байвал зохино.⁵² Эрх зүйн боломжит хамгаалалтын тоонд төрийн эсрэг иргэний нэхэмжлэл гаргах, мөн түүнчлэн хараат бус омбудсмен, хүний эрхийн үндэсний байгууллага зэрэг шүүхийн бус механизм багтана.

Шүүхийн дэмжлэгийг зохистойгоор олж авахын тулд ёс бус хайлтын ажиллагаа нь олж авсан мэдээллийг эзэмшиж буй хэрэглэгчид хор уршиг учруулсанд тооцогдох ёстой. Ёс бус хайлт гэдэг нь нотлогдож чадсан нөхцөлд эдийн болон эдийн бус хохирлын аль алиныг төлүүлэх, мөн түүнчлэн хуулийн үйлчилгээнд төлсөн төлбөр,

⁵⁰ [50] UN Human Rights Committee, *supra*, note 17

⁵¹ [51] This section should be read in conjunction with Access' Guide, *Forgotten Pillar: The Telco Remedy Plan*, May 2013, https://s3.amazonaws.com/access.3cdn.net/fd15c4d607cc2cbe39_0nm6ii982.pdf, which provides information on how telcos can meet their responsibility to provide access to remedy under the UN Guiding Principles on Business and Human Rights.

⁵² [52] *Guiding Principles on Business and Human Rights: Implementing the Protect, Respect, and Remedy Framework*, (2011), HR/PUB/11/04, Guiding Principle 25, ("As part of their duty to protect against business-related human rights abuse, States must take appropriate steps to ensure, through judicial, administrative, legislative or other appropriate means, that when such abuses occur within their territory and/or jurisdiction those affected have access to effective remedy").

нөхөн төлбөрийг олгох боломжтой.⁵³ Мөрдөн шалгах ажиллагаа дуусч, иргэний хэрэг хаагдсаны дараа хууль бусаар олж авсан мэдээллийг шаардлагатай бол хэрэглэгчид эргүүлэн өгөх, бүх хувийг нь шүүгч буюу хууль хэрэглэх эрх бүхий албан хаагчийн хяналтан дор тусгаарлах, устгавал зохино.

Эрх зүйн хамгаалалт үзүүлэх үүрэг нэн тэргүүнд төрд ноогдохын зэрэгцээ, үйлчилгээ үзүүлэгчид нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Эрх зүйн хамгаалалтын асуудлыг хянан шалгах ажиллагаанд хамруулах
- Гомдлын хүртээмжтэй, аюулгүй механизм хэрэгжүүлэх
- Хэрэглэгчдийн гомдолд түргэн шуурхай, үр дүнтэй хариу үзүүлэх.⁵⁴

Үйлчилгээ үзүүлэгчид зөрчлийн сэжиг бүхий үйлдлийг мөрдөн шалгах, нотолгоо хадгалах, шаардлагатай тохиолдолд хүлээн зөвшөөрөх, уучлал гуйх, нөхөн төлбөр төлөх зэргээр хэрэглэгчдэдээ эрх зүйн хамгаалалт үзүүлэхийг дэмжих талаар зохих журам батлах нь зүйтэй.

Хэрэгжилтийн жишээ:

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2.3-т зааснаар Оролцогч улс бүр “энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах” үүрэгтэй.⁵⁵

2. Хууль бусаар олж авсан мэдээллийг хүлээн зөвшөөрөх

Хууль бусаар олж авсан хамгаалагдсан мэдээллийг хууль эрх зүйн ажиллагааны аль ч шатанд хүлээн зөвшөөрөх ёсгүй.

Холбогдох зарчим(ууд): Хууль бус хандалтын эсрэг баталгаа

Дотоодын болон олон улсын хууль, мөн түүнчлэн энэхүү удирдамж дахь горимыг зөрчин олж авсан хамгаалагдсан мэдээллийг хууль эрх зүйн ажиллагааны аль ч шатанд хүлээн зөвшөөрөхгүй (үүнд дээр дурдсан мөрдөн тагнах ажиллагаа, мөн иргэний хэрэг хамаарахгүй).

Ийм мэдээллээс гарсан нотлох баримтыг гэм бурууг нь тогтоохын тулд төрийн хариуцсан агентын эсрэг ажиллагаанаас бусад тохиолдолд шүүхэд авч үздэггүй байх нь зүйтэй. (мөрдөн шалгах үйл ажиллагаа, иргэний эрх зүйн хамгаалалтын

⁵³ [53] See John Ruggie, *Protect, Respect, and Remedy: a Framework for Business and Human Rights*, para. 25, A/HRC/8/5, April 7, 2008, available at <http://www.reports-and-materials.org/sites/default/files/reports-and-materials/Ruggie-report-7-Apr-2008.pdf>.

⁵⁴ [54] Telco Remedy Plan, *supra*, note 47 at 3.

⁵⁵ [55] See also ECHR art. 13; ACHR art. 25

талаар дээрх хэсгээс үзнэ үү)

Хэрэгжилтийн жишээ:

Ирланд улсад, буруутгагдаж буй этгээдийн үндсэн хуулиар эдлэх эрхийг зөрчин олж авсан нотлох баримтыг зөвтгөх хангалттай нөхцөл байхгүй тохиолдолд эрүүгийн хэргийн шүүхээс автоматаар хасдаг.⁵⁶ Хууль бусаар хэдий ч үндсэн хуулиар олгогдсон эрхийн дагуу олж авсан нотлох баримтыг төрийн агентын хууль бус ажиллагааны мөн чанар, хэр хэмжээг илтгэсэн хүчин зүйл бүхий тэнцвэрт хэмжүүрийн дагуу авч хэлэлцэхгүй байж болдог.⁵⁷

3. Засгийн газрын ил тод байдал

Засгийн газрууд хамгаалагдсан мэдээлэл олж авах тухай ирсэн хүсэлт, түүнийг гүйцэлдүүлсэн талаар иж бүрэн тогтмол тоо баримтыг ил тодорхой мэдээлэх үүрэгтэй.

Холбогдох зарчим(ууд): Ил тод байдал ба олон нийтийн хяналт

Улс орнууд харилцаа холбоог мөрдөн тагнах эрх мэдлээ хэрхэн ашигласан талаарх тайланг олон нийтэд ил тодоор мэдээлж, төрийн агентын үйл ажиллагааг нь дотоодын болон олон улсын хуулинд хэрхэн нийцэж буйг илтгэх үүрэг хүлээнэ.⁵⁸

Улс орнуудын ил тод байдлын тайланд дараах мэдээллийг агуулсан байвал зохино. Үүнд:

- Хууль эрхийн акт, хүсэлт гаргагч төрийн оролцогч, үүнд хувь хүн, төрийн агент, газар хэлтэс, бусад нэгжийн дагуу төрөлжүүлсэн хүсэлтийн хэлбэр бүрийн нийт тоо, түүний дотор яаралтай ажиллагаа шаардсан хүсэлтийн нийт тоо
- Үзүүлсэн хариу үйлдлийн нийт тоо, төрөл, түүний дотор татгалзсан хүсэлтийн тоо
- Хайгдаж буй мэдээллийн төрлийн нийт тоо
- Чиглэсэн хэрэглэгчид болон бүртгэл дансны нийт тоо
- Өртсөн хэрэглэгчид болон бүртгэл дансны нийт тоо
- Мэдэгдэлийг хойшлуулах тухай хүсэлтэд заагдсан нийт цаг, үүнээс хангагдсан нийт цаг, хойшлуулах хугацааг сунгасан нийт цаг
- Хүлээн авсан хүсэлтийн нийт хувь болон үүнээс хангагдсан хүсэлтийн нийт хувийг харьцуулсан үзүүлэлт
- Хүлээн авсан хүсэлтийн нийт хувь болон үүнээс эрх зүйн бэрхшээлтэй

⁵⁶ [56] People (DPP) v. Kenny (1990) IR 110

⁵⁷ [57] People (AG) v. O'Brien (1965) IR 142

⁵⁸ [58] State-produced transparency reports act in tandem with, and not separate from, provider reports. More information on what should be in a provider report is available above.

- тулгарсан хүсэлтийн нийт хувийн эрх зүйн бэрхшээлийн үзүүлэлт
- Гаргасан гомдлыг мөрдөн шалгасан тохиолдлын тоо болон эдгээр шалгалтын үр дүн
 - Аливаа мөрдөн шалгах ажиллагааны хариу арга хэмжээ болох эрх зүйн хамгаалалт үзүүлсэн, арга хэмжээ авсан тухай мэдээлэл

Харилцаа холбоог мөрдөн шалгах ажиллагаа хэрхэн явагддагийг ямар ч хүн ойлгохоор тоон болон чанарын мэдээллийг тайлбарлах нь зүйтэй.

Хэрэгжилтийн жишээ:

Эрүүгийн нөхцөл байдалд, ихэнх улс орон өөрсдийн засгийн газрыг мөрдөн шалгах тухай хүсэлт, гүйцэтгэлийн талаарх тоо бүртгэлийг ил тодорхой мэдээлэхийг шаарддаг. Жишээлбэл, Германы Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 100 дугаар зүйл,⁵⁹ Шинэ Зеландын Хайлт хийх болон мөрдөн тагнах тухай 2012 оны хуулийн 170-172 дугаар зүйлүүд⁶⁰ болон Канадын Эрүүгийн хуулийн 195 дугаар зүйлийг⁶¹ үз. Гэсэн хэдий ч аюулгүй байдлын үүднээс бага зэрэг ахиц гарсан. 2014 оны 6 дугаар сард АНУ-ын Үндэсний тагнуулын газрын захирлын алба (ODNI) ил тод байдлын тайлан гаргасан бөгөөд энэ нь Зарчмуудад заагдсан хэм хэмжээнд тооцоолж байсныг бодвол⁶² хүрээгүй.⁶³ Гүүглийн ажилтаны тэмдэглэснээр, ODNI-ийн тайлан тодорхой бус үг хэллэг ашигласан нь үйлчилгээ үзүүлэгчдийн гаргасан тайлантай харилцан холбох “боломжгүй” болгосон.⁶⁴ Түүнээс гадна уг тайланд мэдээллийг хэзээ, хэрхэн ашигласан талаар тодруулаагүйгээрээ мөрдөн тагнах ажил, түүний эрх зүйн байдлыг үнэлэх суурьгүй болж байна.⁶⁵

Бусад улсын хувьд үүнээс тодорхой бус. Өдгөө, Европын зөвлөлийн нэг ч гишүүн улс үндэсний аюулгүй байдалтай холбоотой мөрдөн шалгалт явуулах тухай хүсэлтүүдийг агуулсан ил тод байдлын тайлан гаргаагүй байна.

⁵⁹ [59] Strafprozessordnung [StPO] [Code of Criminal Procedure], April 7, 1987, Bundesgesetzblatt (Federal Law Gazette), I at 1074, as amended, Section 100e “[Duty to Report]”, available at http://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html#p0622

⁶⁰ [60] Search and Surveillance Act 2012, Section 170 “Annual reporting of search and surveillance powers by Commissioner” (N.Z.), available at <http://www.legislation.govt.nz/act/public/2012/0024/latest/DLM3330254.html>

⁶¹ [61] Criminal Code (R.S.C., 1985, c. C-46), Section 195 “Annual report”, available at <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/C-46/page-100.html#docCont>

⁶² [62] Access, *Obama Administration continues to thwart meaningful transparency on NSA surveillance*, Aug. 30, 2013, <https://www.accessnow.org/blog/2013/08/30/obama-administration-continues-to-thwart-meaningful-transparency-on-nsa-sur>.

⁶³ [63] *Statistical Transparency Report Regarding Use of National Security Authorities - Annual Statistics for Calendar Year 2013*, IC on the Record, June 26, 2014, http://icontherecord.tumblr.com/transparency/odni_transparencyreport_cy2013

⁶⁴ [64] Richard Salgado, *A step toward government transparency*, Google Public Policy Blog, June 27, 2014, <http://googlepublicpolicy.blogspot.com/2014/06/a-step-toward-government-transparency.html>.

⁶⁵ [65] Steven Aftergood, *ODNI Declassifies Data on Frequency of Surveillance*, Federation of American Scientists, June 30, 2014, <http://fas.org/blogs/secrecy/2014/06/odni-frequency/>

Олон улсын хамтын ажиллагаа

1. Хууль дүрмийн сонголт

Төрийн агент гадаадын шүүх эрх мэдлийн байгууллагаас хамгаалагдсан мэдээлэл хүссэн тохиолдолд, дэмжлэг авах тухай хүсэлт гаргахдаа олон нийтэд нээлттэй олон улсын албан ёсны шугамыг ашиглавал зохино.

Холбогдох зарчим(ууд): Олон улсын харилцаа холбооны баталгаа

Төрийн агент гадаадын шүүх эрх мэдлийн байгууллагаас хамгаалагдсан мэдээлэл хүсэхдээ олон улсын албан ёсны холбогдох шугамыг дагана. Олон улсын албан ёсны холбогдох шугамын талаарх нарийвчилсан мэдээлэл олон нийтэд нээлттэй байна. Ингэхдээ хэлэлцээрт өртөж болзошгүй нийт хэрэглэгчид, мөн түүнчлэн түүнийг хэрэгжүүлэх үүрэг хүлээгч бүх талуудад хүртээмжтэй байхаар хэлэлцээрт оролцогч улсуудын улсын албан ёсны болон зонхилох хэл дээр үйлдсэн байх шаардлагатай.⁶⁶

Олон улсын албан ёсны шугам нь хэд хэдэн шүүх эрх мэдлийн ажиллагаа оролцсон нөхцөлд аль хуулийг хэрэглэх талаар тодорхой удирдамж гаргах нь зүйтэй. Сонголттой тулгарах үед тус шугам нь хувь хүний эрхийг хамгаалах дээд зэргийн хэм хэмжээ баримтлахыг шаардах ёстой. Олон улсын албан ёсны шугам улс орнуудын дэмжлэг авах тухай хүсэлтэд илэрхийлсэн хамгаалагдсан мэдээллийн хамрах хүрээг тодорхойлох, мөн уг хүсэлтийн дагуу гүйцэтгэсэн харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг гүйцэтгэхдээ энэхүү хэрэгжилтийн удирдамжид заагдсан хэм хэмжээнд нийцүүлэхийг шаардах ёстой. Олон улсын албан ёсны шугам онцгой нөхцөл байдлын үед хэрхэн ажиллах, түүний дотор онцгой байдлыг ямар хүчин зүйл тогтоосон, дагаж мөрдөх журам, шаардагдах бичиг баримт, мөн түүнчлэн дагалдах зөвшөөрлийн хэрэгцээ шаардлага зэргийг агуулсан тодорхой удирдамж гаргах нь зүйтэй.

Хэрэгжилтийн жишээ:

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ нь албан ёсны гэрээ бөгөөд түүнийг НҮБ-д бүртгүүлж, ил тодорхой болгох үүрэгтэй.⁶⁷ Хууль хэрэгжүүлэх хамтын ажиллагааны хэлэлцээр, гэрээнээс доогуур статустай хэлэлцээрүүд нь энэхүү үүрэгт багтаагүй бол улс орнууд нь эдгээрийг мөн ил тодорхой болгох нь зүйтэй.⁶⁸

⁶⁶ [66] Access is working to make MLATs more publicly accessible through www.mlainfo.org

⁶⁷ [67] U.N. Charter art. 1.

⁶⁸ [68] See e.g., *Rush v Commissioner of Police* [2006] 150 FCR 165 (Finn J) (Austl.).

2. Хариу үйлдэл үзүүлэх эрх бүхий этгээд

Гадаадын засгийн газруудаас ирүүлсэн хамгаалагдсан мэдээллийн талаарх дэмжлэг хүссэн өргөдлийг хүсэлт гаргагч нь олон улсын албан ёсны шугамыг дагаж мөрдсөн тохиолдолд гүйцэтгэх үүрэгтэй. Шүүхийн эрх бүхий байгууллага хамгаалагдсан мэдээлэлд хандах дэмжлэгийн хүсэлт нь хуулинд нийцэж, энэхүү удирдамжид заагдсан хэм хэмжээнд зохицсон тохиолдолд хандалтыг зөвшөөрөх ёстой.

Холбогдох зарчим(ууд): Олон улсын харилцаа холбооны баталгаа ба зохих ёсны ажиллагаа

Аливаа улс өөр улсын хадгалж буй хамгаалагдсан мэдээллийг авах тухай хүсэлт гаргахад, хүсэлт хүлээн авагч улс нь уг хүсэлтийн хүчин төгөлдөр байдал, хамгаалагдсан мэдээллийн хандалтыг шаардсан эрх зүйн үндэслэл болоод нягтлан шалгаж, шаардагдах харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны хамрах хүрээ, аргачлал нь олон нийтэд нээлттэй Олон улсын албан ёсны шугам, олон улсын хууль болон энэхүү удирдамжид нийцэж буй эсэхийг нягтлан шалгах үүрэгтэй. Шүүхийн эрх бүхий байгууллага нь дээрх хүсэлтийг хянан шалгаж, хамгаалагдсан мэдээлэлд аливаа хайлт хийх, түүнийг дамжуулах ажиллагаа эхлэхээс өмнө зөвшөөрөл олгох ёстой. Хүсэлт гаргагч улс энэ ажиллагаа нь дотоодын болон олон улсын хуулийн дагуу хүлээсэн тэдний үүрэг хариуцлагад нийцэж, дотоодын эрх зүйн бүхий л хууль эрх зүйн үйл явцыг даган мөрдсөн талаар баталгаа гарган, түүнийгээ илэрхийлэх шаардлагатай.

3. Онцгой нөхцөл байдлын ажиллагаа

Онцгой нөхцөл байдалд хамгаалагдсан мэдээлэл авах тухай хүсэлтийг олон улсын албан ёсны тохирохуйц шугамын удирдамжийн дагуу гаргавал зохино. Уг хүсэлтийг (1) захиргааны журмаар, (2) шүүхийн эрх бүхий байгууллагын түр захирамжийн дагуу гаргана.

Холбогдох зарчим(ууд): Хууль зүйн үндэслэлтэй байх, эрх бүхий шүүх эрх мэдлийн байгууллага, зохих ёсны ажиллагаа болон хууль бус хандалтын эсрэг баталгаа

Төрийн агент захиргааны журмын хүсэлт буюу шүүхийн эрх бүхий байгууллагын захирамж эрэлхийлэхдээ хамгаалагдсан мэдээлэл авах тухай хүсэлтийг онц нөхцөл байдлын дэргэдэх олон улсын албан ёсны шугамаар дамжуулан гаргана. Ямар ч тохиолдолд төрийн агент харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг шүүхийн эрх бүхий байгууллага, хүсэлт хүлээн авагч улс гаргаагүй гэсэн итгэл үнэмшил төрүүлэхүйц үндэслэлтэй шалтгааныг баталгаажуулах ёстой. Онц байдлын нөхцөл дор үйлдсэн дэмжлэг авах тухай хүсэлт гармагц, хүсэлт гаргасан улс нь олон улсын

албан ёсны шугамаар дамжуулан дагалдах зөвшөөрлийн хүсэлтийг ердийн хэлэлцээрийн дагуу гаргана. Хэрэв хүсэлт гаргагч, хүлээн авагч улсын аль аль нь төрийн агент онц нөхцөл байдал цуцлагдсан гэж тогтоосон бол оролцогч талууд ердийн журмандаа эргээд орно.⁶⁹

4. Баталгаа ба татгалзах үндэслэл

Хамгаалагдсан мэдээллийг олон улсын шугамаар дамжуулах тухай бүх гэрээ хэлэлцээр нь хүний эрхийн хамгаалалтыг агуулсан байвал зохино. Улс орнууд нь эрх зүйн тогтолцоогоор хүний эрхийг хамгаалдаг улс орнуудтай гагцхүү харилцаа, хамтын ажиллагаа явуулах ёстой. Улс орнууд хэрэглэгчийн мэдээлэл хүссэн аль ч хүсэлт нь олон улсын хууль, бодлого, хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж буй эсэхийг нягтлах шаардлагатай.

Холбогдох зарчим(ууд): Олон улсын харилцаа холбооны баталгаа

Олон улсын албан ёсны бүхий л шугам нь хүний эрхийн хамгаалалтыг агуулсан байх шаардлагатай. Гэрээ хэлэлцээр нь хүсч буй хамгаалагдсан мэдээлэлд үндэслэсэн эрүү шүүлтэд өртөх, цаазар авах ял авсан хэрэглэгчид ноцтой эрсдэл учрах зэрэг хүний эрхийн ноцтой асуудал үүсгэсэн дэмжлэг авах тухай аливаа хүсэлтийг биелүүлэхээс татгалзахыг шаардсан байвал зохино. Гэмт үйлдэл, эс үйлдэл гэмт хэрэг илтгэсэн тохиолдолд хүсэлт хүлээн авсан улсад гарсан бол хамгаалагдсан мэдээллийг гаргаж өгөх ёстой.

Улс орнууд хоорондын хамтын ажиллагааны гэрээ хийхийн өмнө эрүүгийн эрх зүйн тогтолцоо нь хүний эрхийн хамгаалалтыг хангалттай үзүүлж буй эсэхэд харилцан дүн шинжилгээ хийх шаардлагатай. Улс орнууд бусад улс орнууд хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буйг баталгаажуулахын тулд эдгээр үнэлгээг тогтмол эргэн нягталж байх нь зүйтэй.

Хэрэгжүүлж буй жишээ:

АНУ-ын эрүүгийн гэмт хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх загвар гэрээний 4 дүгээр зүйлд улс төрийн гэмт хэрэгт хамаарах, давхар аюул дагуулах, арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, яс үндэс, угсаатны гарал үүсэл, улс төрийн үзлийн үндсэн дээр мөрдөн хавчих асуудалтай холбоотой нөхцөл байдалд үндэслэн татгалзах үндэслэлийг заасан байдаг. Гэсэн хэдий ч эдгээр нь заавал биелүүлэх хамгаалалт биш юм.⁷⁰

⁶⁹ [69] Similar emergency protocols exist for international asset recovery; see Jean-Pierre Brun et al., *Asset Recovery Handbook: A Guide for Practitioners*, The World Bank and United Nations Office on Drugs and Crime, 135-6, 2011, available at http://www.unodc.org/documents/corruption/Publications/StAR/StAR_Publication_-_Asset_Recovery_Handbook.pdf

⁷⁰ [70] UN General Assembly, *Model Treaty on Mutual Assistance in Criminal Matters: resolution I adopted by the General Assembly*, April 3, 1991, A/RES/45/117, available at: <http://www.refworld.org/docid/3b00f21e1c.html>

ХАВСРАЛТ А:

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд олон улсын хүний эрхийн зарчмуудыг баримтлах нь

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛТЭЙ БАЙХ

Хүний эрхийн аливаа хязгаарлалт хуулиар тогтоогдсон байх шаардлагатай. Аливаа улс тодорхой байх хэм хэмжээнд нийцсэн, хувь хүмүүст урьдчилан мэдэгдэх, хэрэглэх явцыг урьдчилан тооцоолох боломж олгох тухай нарийвчилсан заалт бүхий нийтэд нээлттэй эрх зүйн акт байхгүй тохиолдолд эдгээр эрхэнд харшлах арга хэмжээг батлах буюу хэрэгжүүлэх ёсгүй. Технологийн дэвшлийн хурдыг харгалзан үзэж, хүний эрхийг хязгаарласан хуулиудыг оролцоонд тулгуурласан эрх зүйн болон зохицуулалтын арга замын дагуу тогтмол дүгнэн хэлэлцэх шаардлагатай.

ХУУЛЬ ЁСНЫ ЗОРИЛГОТОЙ БАЙХ

Төрийн эрх бүхий тодорхой байгууллагын харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай эрх зүйн тэргүүн зэргийн ашиг сонирхолд нийцэхүйц хууль ёсны зорилгод хүрэхийн тулд гагцхүү хуулиар зөвшөөрнө. Аливаа арга хэмжээг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хэрэгжүүлэх ёстой.

ШААРДЛАГАТАЙ БАЙХ

Мөрдөн тагнах тухай хууль тогтоомж, зохицуулалт, үйл ажиллагаа буюу эрх мэдэл бүхий байгууллага нь хууль ёсны зорилгод хүрэхэд шаардлагатай хүчин зүйлээр хязгаарлагдсан байвал зохино. Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг явуулахдаа энэ нь хууль ёсны зорилгод нийцэх цорын ганц арга болох тохиолдолд аль эсвэл хэд хэдэн аргаас хүний эрхэнд хамгийн багаар халдахуйц арга байгаа тохиолдолд явуулна.

НИЙЦЭХҮЦ БАЙХ

Харилцаа холбоог мөрдөн тагнах хуулиар зөвшөөрөгдсөн аливаа ажиллагаа нь хууль ёсны тодорхой тогтоогдсон зорилгыг биелүүлэхэд тохирсон байвал зохино.

ДҮЙЦЭХҮЙ БАЙХ

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа нь хүний эрхэнд халдсанаар ардчилсан нийгмийн үндэс сууринд заналхийлсэн залхаан цээрлүүлэх ажиллагаанд тооцогдох ёстой. Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай шийдвэрийг нэвтэрсэн мэдээллийн мэдрэмжтэй байдал болоод хүний эрх болон бусад янз бүрийн эрх ашгийн зөрчлийн ноцтой байдлыг харгалзах ёстой. Энэ нь тухайн улсыг хууль сахиулах, үндэсний аюулгүй

байдлыг сахин хамгаалах, мэдээ мэдээлэл цуглуулах зорилгоор харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулахын өмнө наад зах нь шүүхийн эрх бүхий байгууллагад дараах тохиолдлыг хуульчлан тогтоох шаардлагатай:

1. Ноцтой гэмт хэрэг эсвэл хууль ёсны зорилгод тодорхой заналхийлэл учирч буй, эсвэл учрах өндөр магадлал буй
2. Ноцтой гэмт хэрэг эсвэл хууль ёсны зорилгод тодорхой заналхийллийг нотлох баримт, материалыг хайгдаж буй хамгаалагдсан мэдээлэлд хандсанаар олж авах өндөр магадлал буй
3. Бусад харьцангуй бага хор хөнөөлтэй арга хэрэгслийг ашиглах буюу хэрэглэсэн арга нь харьцангуй бага хор хөнөөлтэй байх
4. Нэвтэрсэн мэдээлэл нь ноцтой гэмт хэрэг буюу хууль ёсны зорилгод учрах тодорхой заналхийлэл зохистой бодит хэмжээ хүртэл хязгаарлагдах
5. Цуглуулсан мэдээллийн аливаа илүүдсэн хэсгийг хадгалахгүй боловч үүний оронд сайтар устгах буюу буцаана
6. Мэдээллийг гагцхүү тусгай эрх бүхий байгууллага олж авах бөгөөд зөвшөөрөл олгогдсон зорилго болон хугацааны дагуу ашиглана.
7. Хийхээр хүсэлт гаргасан мөрдөн тагнах ажиллагаа, үүнийг хэрэгжүүлэхээр санал болгож буй арга хэрэгсэл нь хувийн нууцтай байх эрх, үндсэн эрх чөлөөний мөн чанарыг дордуулахгүй байх.

ЭРХ БҮХИЙ ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГА

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаатай холбогдох тодорхойлолтуудыг эрх бүхий шүүхийн хараат бус, шударга байгууллага гаргах ёстой. Эрх бүхий байгууллага нь:

1. Бие даасан бөгөөд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллагаас хараат бус байх
2. Холбогдох асуудлаар мэдлэг туршлагатай бөгөөд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны хууль зүйн үндэслэл, арга хэрэгсэл, хүний эрхийн талаар шүүхийн шийдвэр гаргах чадвартай байх
3. Ноогдсон үүргээ биелүүлэх хангалттай нөөц бололцоотой байх

ЗОХИХ ЁСНЫ АЖИЛЛАГАА

Зохих ёсны үйл ажиллагаа нь улс орнуудаас хүний эрхэнд халдсан аливаа хууль ёсны үйл ажиллагааг хуулинд сайтар зүйлчилж, тогтвортойгоор дагаж мөрдөн, олон нийтэд нээлттэй байдлыг хангаснаар хүний эрхийг хүндэтгэн, хамгаалахыг шаардана. Тухайлбал, бусдын амь насанд заналхийлж буй аюул тулгарсан онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд хүний эрхээ баталгаажуулахдаа хүн бүр зохистой хугацааны турш шударга нээлттэй шүүх хурал хуулийн дагуу бий болсон хараат бус, нэр хүндтэй, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй. Ийм тохиолдолд, буцаан хэрэглэх хүчинтэй зөвшөөрлийг хэрэгжүүлж болохуйц зохистой цаг хугацааны дотор эрэлхийлэх шаардлагатай. Нотлох баримт алга болох, устгагдах бодит эрсдэлийг буцаан хэрэглэх хүчинтэй зөвшөөрлийг зөвтгөх хангалттай хүчин зүйл хэмээн тооцох учиргүй.

ХЭРЭГЛЭГЧДЭД МЭДЭГДЭХ

Харилцаа холбоо нь мөрдөн тагнагдаж буй этгээдэд харилцаа холбоог мөрдөн шалгахыг зөвшөөрсөн шийдвэрийн талаар тэдэнд шийдвэрийг маргах, эрх зүйн бусад хамгаалалт эрэлхийлэхэд нь хангалттай хугацаанд мэдэгдэх шаардлагатай. Мөн зөвшөөрөл олгохтой холбогдох баримт бичигтэй танилцах боломж олговол зохино. Мэдэгдэл хойшлуулахыг дараах нөхцөлд зөвтгөнө:

1. Мэдэгдэл нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг явуулах зөвшөөрлийг олгосон зорилгод ноцтой аюул учрах, эсвэл бусдын амь насанд аюул учрах эрсдэл бий болох
2. Мэдэгдэл хойшлуулах зөвшөөрлийг эрх бүхийн шүүхийн байгууллага олгоно
3. Өртсөн хэрэглэгчид эрх бүхий шүүхийн байгууллагын тогтоосноор эрсдэл арилмагц мэдэгдэнэ

Мэдэгдэл хүргүүлэх үүрэг төрд оногдох хэдий ч харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчид харилцаа холбоог мөрдөн хянах ажиллагааны талаар хувь хүмүүст сайн дураар буюу тэдний хүсэлтийн дагуу мэдэгдэл өгөхөд саад учрах ёсгүй.

ИЛ ТОД БАЙДАЛ

Улс орнууд харилцаа холбоог мөрдөн тагнах тухай хууль, журам, зохицуулалт, үйл ажиллагаа, эрх мэдлийн зорилго, хамрах хүрээ болоод эрх бүхий байгууллагын асуудлаар ил тод байх үүрэгтэй. Ингэхдээ наад зах нь баталгаажсан болон татгалзсан хүсэлтийн нарийвчилсан тооны ангилагдсан мэдээлэл, хүсэлтийг үйлчилгээ үзүүлэгч, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, төрөл зүйл, зорилго болоод өртсөн хувь хүмүүсийн нарийвчилсан тоо нь ангилсан мэдээллийг ил тодорхой болгох шаардлагатай. Улс орнууд нь хувь хүмүүсийг харилцаа холбооны мөрдөн тагнах ажиллагааг зөвшөөрсөн хуулиудын хамрах хүрээ, мөн чанар, хэрэглээний талаар бүрэн дүүрэн ойлголт өгөхөд хүрэлцэхүйц мэдээллээр хангах нь зүйтэй. Улс орнууд үйлчилгээ үзүүлэгчийн улсаас мөрдөн байцаах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг гүйцэтгэх явцдаа хэрэглэж буй журам, эдгээр журмуудыг мөрдөх, улсаас харилцаа холбоог мөрдөн тагнах тухай хүсэлтийг бүртгэл мэдээллийг ил тодорхой болгох эрмэлзэлд хөндлөнгөөс оролцох ёсгүй.

ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ

Улс орнууд нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор хяналтын хараат бус механизм бий болгох шаардлагатай. Хяналтын механизм нь дараах бүрэн эрхтэй. Үүнд: төрийн үйлдлийн талаарх холбогдох боломжит бүх мэдээлэлд, түүний дотор зохистой үед нууц мэдээлэлд нэвтрэх; төр эрх зүйн чадамжаа хуулийн дагуу ашиглаж буй эсэхэд үнэлгээ хийх; ил тод байх үүргийнхээ дагуу харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа, хамрах хүрээний талаар иж бүрэн, үнэн зөв мэдээллийг нээлттэй болгосон эсэхэд дүгнэлт өгөх; харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаатай холбогдох тайлан, бусад төрлийн мэдээллийг тогтмол нийтлэх,

эдгээр үйлдлийн хууль ёст байдлыг, түүний дотор эдгээр Зарчмуудад хэрхэн нийцэж буй хэр хэмжээг нээлттэй тогтоох. Хараат бус хяналтын механизмуудыг засгийн газрын бусад салбарын өмнө нь тогтоосон аливаа хяналттай зэрэгцэн байгуулна.

ХАРИЛЦАА ХОЛБОО БОЛОН СҮЛЖЭЭНИЙ БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ

Харилцаа холбооны сүлжээний бүрэн бүтэн, аюулгүй, халдашгүй байдлыг хангахын тулд, төр өөрийн зорилгодоо аюулгүй байдлыг хөндөх нь аюулгүй байдлын асуудлыг ерөнхийд нь хөнддөг гэдгийг хүлээн зөвшөөрч, улс орнууд нь үйлчилгээ үзүүлэгчид, техникийн болон программ хангамжийн борлуулагчдыг сүлжээндээ мөрдөн хяналт, хяналт шинжилгээ тогтоох, төрийн дан харилцаа холбоог мөрдөн тагнах зорилгоор тодорхой мэдээллийг цуглуулах, хадгалахыг албадах ёсгүй. Үйлчилгээ үзүүлэгчдээс өгөгдлийг урьдчилан хадгалах, цуглуулахыг шаардах ёсгүй. Хувь хүн өөрийгөө илэрхийлэхдээ нэрээ нууцлах эрх эдлэх ёстой. Тиймээс улс орнууд хэрэглэгчдийн тодорхойлолтыг гаргуулахаар албадахаас зайлсхийвэл зохино.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАТАЛГАА

Мэдээллийн урсгал, харилцаа холбооны технологи, үйлчилгээний өөрчлөлтийг харгалзан, улс орнууд гадаад улс орнуудаас болон үйлчилгээ үзүүлэгчдээс дэмжлэг туслалцаа эрэлхийлж болно. Тиймээс эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ болон улс орнуудын байгуулж буй бусад гэрээ хэлэлцээрүүд нь нэгээс дээш улсын хууль тогтоомж нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд нийцэх, хувь хүмүүст өндөр хэмжээний хамгаалалт өгсөн мөрдөгдөж буй хэм хэмжээг ашиглах. Улс орнууд хууль сахиулах зорилгоор туслалцаа эрэлхийлж байгаа тохиолдолд “давхар гэмт хэрэг”-ийн зарчмыг ашиглаж болно. Улс орнууд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг хязгаарласан дотоодын хуулийн зохицуулалтын хүрээнд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх процесс болон хамгаалагдсан мэдээлэлд хандах тухай гадаадаас ирүүлсэн хүсэлтийг ашиглахгүй байж болно.

ХУУЛЬ БУС ХАНДАЛТЫН ЭСРЭГ БАТАЛГАА БА ЭРХ ЗҮЙН ҮР НӨЛӨӨТЭЙ ХАМГААЛАЛТ АВАХ ЭРХ

Улс орнууд төрийн болон хувь этгээдийн зүгээс хууль бусаар харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг гэмт хэрэг болгон зүйлчлэх үүрэгтэй. Хуулиар иргэний болон эрүүгийн хариуцлага, шүгэлдэгчийн хамгаалалт, ертөгсдийн хохирлыг нөхөн төлөх арга замыг хангалттай тогтоох нь зүйтэй. Эдгээр зарчмуудад харшлах замаар олж авсан аливаа мэдээлэл нь нотлох баримтанд хүлээн зөвшөөрөшгүй, эдгээр мэдээллээс үүдсэн аливаа нотолгоог шүүхийн аль ч шатанд авч хэлэлцдэггүй байх талаар тогтоох ёстой. Улс орнууд нь харилцаа холбоог мөрдөн тагнах замаар олж авсан аливаа баримт бичгийг уг мэдээллийн өгөгдсөн зорилгод ашиглахгүй, уг баримт бичгийг хадгалахгүйгээр устгалд оруулах аль эсвэл өртсөн этгээдэд эргүүлэн өгөхийг хуулиар зохицуулах шаардлагатай.

ХАВСРАЛТ В:

Зарчмуудыг хэрэгжүүлэх удирдамжийн хяналтын жагсаалт

I. Хүсэлт гаргах

- Олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй хуулинд үндэслэх
- Дан ганц зорилтонд хэрэглэх
- Хамгаалагдсан мэдээллийн үр нөлөөг багасгахад нарийн тохируулах
- Төрийн агент үйлдэн, баталгаажуулах, хүсэлтийг агуулга, шаардлага хангах байдалд үндэслэн үнэлгээ өгөх хараат бус, эрх бүхий шүүхийн байгууллагаар баталгаажуулах
- Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд хамрагдах бүртгэл, тоног төхөөрөмж, хадгалагч, хайгдаж буй мэдээлэл, санамсаргүйгээр нэвтэрсэн аливаа хамгаалагдсан мэдээлэл, ашиглах арга зам, харилцаа холбоог мөрдөн хянах үйл ажиллагаа явуулах тодорхой цаг хугацааг нарийн тодорхойлох
- Хайгдаж буй хэрэгцээт мэдээлэл нь бүртгэлд бий эсэхийг шалган тогтоох
- Тоног төхөөрөмж, хадгалагчийг харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд тодорхойлох
- Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа болон хайгдаж буй шаардлагатай мэдээлэлтэй холбоотой бүртгэл, тоног төхөөрөмж, хадгалагчийн хоорондын уялдаа холбоог харуулах
- Онц байдлын үед дагаж мөрдөх журмыг ашиглах тохиолдолд албан ёсны өргөдлийг хайлт хийхийг сэдсэнээс хойш 24-72 цагийн дотор гаргана.

II. Шүүхийн тогтоол

- Хараат бус, шударга, эрх бүхий шүүхийн байгууллага гаргаж, баталгаажуулна
- Олон нийтийн, ил тод шүүн таслах ажиллагааны дагуу
- Хуулийн дагуу, найдвартай олж авсан мэдээлэлд үндэслэх
- Бичгээр эрх бүхий шүүхийн нийт үндсэн байгууллагыг тодорхойлж, хүсэлтийг хавсаргах
- Зөвшөөрлийн бүрэн хамрах хүрээг, түүний дотор харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд холбогдох бүртгэл, тоног төхөөрөмж, хадгалагч, мөн түүнчлэн уг ажиллагаа явагдах хугацаа, аргачлалыг тодорхойлох
- Хамгаалагдсан мэдээлэлд санамсаргүй нэвтрэх боломжийг аль болох багасгах талаар нарийвчилсан
- Хамгаалалттай бүх мэдээллийн хадгалалтыг зохистой хугацаагаар хязгаарлахдаа харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны хууль ёсны зорилгын тухай шийдвэрт зааснаас хэтрүүлэхгүй байх
- Шинээр үүссэн нийт нөхцөл байдал, онцгой баримт, эсвэл эрх зүйн бүхий л

- асуудлаарх шийдвэрийн үндэслэл, тайлбарыг бичгээр оруулах
- Хайлт хийх явцад олж авсан хамгаалалттай бүхий л мэдээллийн талаар, түүний дотор цуглуулах, нэвтрэх, хадгалах, зайлшгүй устгах явцын талаар тайлагнахыг шаардах
 - Онц байдал тогтоосон нөхцөлд, төрийн агентын хүсэлтийг зохистойгоор гүйцэлдүүлэхэд шаардагдах хугацаагаар эрх мэдлийг хязгаарлах

II. Үйлчилгээ үзүүлэгчийн хариу үйлдэл

- Гагцхүү бичгээр үйлдсэн хүсэлтэнд, түүний дотор хүсэлт гаргагч төрийн агентын тодорхойлолт, мөн түүнчлэн харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны хамрах хүрээ, хугацаа, аргачлалын талаар нарийн тодорхойлсон тохиолдолд хариу өгөх
- Дотоодын болон олон улсын хуулийн хамрах хүрээнээс гадуурх бүхий л эсэргүүцвэл зохих хүсэлтийг албан ёсоор эсэргүүцэх
- Хуулиар хориглоогүй тохиолдолд хүсэлтийн талаар хэрэглэгчид мэдэгдэл өгөхийг шаардах
- Хайлтыг хүсэлтийн хүрээгээр хязгаарлах, шаардагдахуйц хамгийн хязгаарлагдмал бүтцээс илүү мэдээлэл олгохгүй байх
- Нийт хүсэлтийг баримтжуулан, ил тод байдлын тайланг тогтмол гаргах

III. Шүүхийн тогтоолын хэрэгжилт

- Чиглэсэн этгээдэд шүүхийн шийдвэрийн талаар мэдэгдэх, хойшлуулах шаардлагатай байсан гэдгийг илэрхийлэх баримт байхгүй тохиолдолд хайлтын үндэслэлийг эсэргүүцэх хангалттай боломжоор хангах
- Хайлтын явцад олж авсан хамгаалалттай бүх мэдээллийн талаар эрх бүхий шүүхийн байгууллагад тогтмол эргэн мэдээлэх
- Холбогдох мэдээллийг ангилах, хамааралгүй мэдээллийг нэн даруй хэрэгсэхгүй болгох, хэрэг дуусах буюу дахин хэрэгцээгүй болсон тохиолдолд нотлох баримтуудыг устгах
- Олон улсын шүүх эрх мэдлийн байгууллагаас(д) гаргасан аливаа хүсэлтэд олон улсын албан ёсны шугамыг мөрдөнө
- Хууль бусаар олж авсан хамгаалалттай мэдээллийг шүүн таслах аливаа үйл ажиллагаанд ашиглах, цаашдын мөрдөн шалгах үйл ажиллагааны үндэс болгохоос урьдчилан сэргийлэх
- Холбогдох бүх зардлыг зохих хугацааны дотор үйлчилгээ үзүүлэгчдэд нөхөн олгох
- Харилцаа холбоог мөрдөн тагнах эрх мэдэл, практик хэрэглээний талаарх тогтмол нийтлэгдэх ил тод байдлын тайлангийн хүрээнд эмхэтгэх.

ХАВСРАЛТ С:

Жишээ баримт 1: Чилийн Твиттер дэх элэглэлийн жишээ

2011 онд блогч Родриго Феррари нь твиттерт “@losluksic” хаягтай бүртгэл үүсгэсэн байдаг. Уг бүртгэлд Чилийн хамгийн баян гэр бүлүүдийн нэг Люксикийн гэр бүлийн гурван гишүүний зургийг байрлуулжээ.⁷¹ Эдгээр хүмүүсийн зургийн ар талд мөнгөн дэвсгэртийн дүрс оруулсан байна. Тухайн хаягнаас “tenemos cualquier plata” (“бид маш их мөнгөтэй”) зэрэг утгатай сэтгэгдлүүд жиргэжээ.

Гэр бүлийн гишүүдийн нэг болох Андронико Люксик дээрх бүртгэл болон өөр бусад хоёр бүртгэл (“@andronico_luksic” болон “@luksic_andronico”) үүсгэсний төлөө эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр гомдол гаргасан байна.

Бусдын хувийн шинж чанарыг ашигласан гэх дан ганц элемент бүхий гомдол нь нэр булаан эзэмших (“usurpación de nombre”) гэмт хэрэгт үндэслэсэн. Твиттер нь Чилийн шүүх эрх мэдлээс гадуур. Учир нь түүний удирдах байгууллага болон серверүүд нь Калифорнид байрладаг. Тиймээс, Чилийн олон нийтийн асуудлаарх яамны албан хаагч Эрүүгийн хэргийн талаарх харилцан туслалцааны Америк дундын гэрээний дагуу АНУ-ын засгийн газарт хандан Твиттерийн бүртгэлүүдийн IP хаяг, эзэмшигчийн тодорхойлолт, харилцаа холбоог олж авах талаар хүсэлт гаргажээ. Тухайн албан хаагч Чилийн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу шүүхээс зөвшөөрөл авах тухай гол алхамыг алгассан байна.⁷²

Дээрх хүсэлтийн дагуу Твиттер тухайн албан хаагчид IP хаягийг гаргаж өгчээ. Үүний дараа прокурор Чилийн V.T.R. Telecomunicaciones гар утасны үйлчилгээ эрхлэгчид хандан IP хаягт холбогдох ISP бүртгэлийн мэдээллийг хүсчээ. V.T.R. Telecomunicaciones нь Родриго Ферраригийн мэдээллийг гарган өгчээ. Хэдийгээр Феррари нь зөвхөн “@loslukic” бүртгэлийн эзэмшигч боловч цагдаагийн буруу ташаа, дутуу мэдээлэлд үндэслэн түүнийг бүх гурван бүртгэлийг үүсгэсэн хэмээн буруутган, ялласан байна. 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Чилийн шүүхээс “@losluksic” хэмээх бүртгэл нь элэглэлийн шинж чанартай бөгөөд Феррарид шийтгэл ноогдуулах нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг зөрчсөн явдал болно хэмээн үзээд түүний хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

⁷¹ [71]Forbes, Worlds Richest Families: Andronico Luksic & family (2005), available at <http://www.forbes.com/static/bill2005/LIR0CJD.html>.

⁷² [72] Unlike U.S. law, which does not require a court order for subscriber information, Chilean law dictates that any search for information must be approved by a judicial authority.

Сургамж

Чилийн засгийн газар

- Чилийн албан хаагч нь АНУ-ын засгийн газарт хүсэлт гаргахаас өмнө, мөн дахин V.T.R. Telecomunicaciones гар утасны үйлчилгээ эрхлэгчид хүсэлт гаргахаас өмнө шүүхийн байгууллагаас зөвшөөрөл авах ёстой байсан. (зохих ёсны ажиллагаа)
- Чилийн Олон нийтийн асуудлаарх яам АНУ-д хүсэлт гаргахдаа Чилийн хууль тогтоомжийн дагуу бүхий л шаардлага хангагдсан эсэхийг нягтлах шаардлагатай байсан. Үүний дотор шүүхээс зөвшөөрөл, мөн түүнчлэн дээрх хуулийн дагуу шүүхэд татах нь зохистой эсэх өргөн хүрээний асуудлыг багтаана. (зохих ёсны ажиллагаа, хууль зүйн үндэслэлтэй байх, дүйцэхүйц байх)
- Гурван бүртгэлийн асуудал хөндөгдөж буй учир, Чилийн албан хаагч болон Чилийн Олон нийтийн асуудлаарх яам нь бүртгэл тус бүр дээр хайлт хийх хүсэлтийг тус тусд нь гаргах ёстой байв. (дүйцэхүйц байх)

АНУ-ын засгийн газар

- АНУ-ын засгийн газар хүсэлтийг “давхар гэмт хэрэг”-ийн нөхцөлд нийцэж буйг шаардах, ялангуяа үг хэлэх эрх чөлөөний хамаарлыг харгалзах (хууль ёсны байх)
- АНУ-ын Хууль зүйн департамент нь АНУ-ын шүүхээс хамгаалалттай мэдээлэл болох IP хаягт нэвтрэх зөвшөөрөл хүсэх ёстой байв. (эрх бүхий шүүх эрх мэдлийн байгууллага)

Твиттер

- Твиттер нь хүсэлт тодорхой эсэхийг нягтлах, хайлт хийх зөвшөөрөл хуулийн зохих процедурын дагуу олгогдсон эсэхийг баталгаажуулах ёстой байсан. (шаардлагатай байх, нийцэхүйц байх, хууль зүйн үндэслэлтэй байх, дүйцэхүйц байх)

Гар утасны үйлчилгээ эрхлэгч V.T.R. Telecomunicaciones компани

- V.T.R. Telecomunicaciones компани нь шүүхийн тогтоол гарах хүртэл Чилийн албан хаагчийн эрэлхийлж буй мэдээллийг өгөхөөс татгалзах ёстой байв. (зохих ёсны ажиллагаа).

Чилийн шүүх

- Чилийн шүүх Ферраригийн эсрэг гаргасан гомдлыг хэлэлцэхдээ тухайн бүртгэл нь хамгаалалттай илэрхийллийн хэлбэр болох элэглэл гэдгийг хүлээн

- зөвшөөрсөн нь зөв үйлдэл байсан.⁷³ (хууль бус хандалтын эсрэг хамгаалалт)
- Шүүх нь Чилийн албан хаагч, Ферраритай холбоотой бүх мэдээллээс татгалзсан эсэхийг магадлах ёстой байсан. (хууль бус хандалтын эсрэг хамгаалалт)
 - Эрүүгийн, иргэний буюу сахилгын шийтгэлийг албан хаагч болон Олон нийтийн асуудлаар яаманд ноогдуулах ёстой байв.

⁷³ [73] Renata Avila, #FreeRod: Preliminary Victory in Chilean Twitter Parody Case, GlobalVoices Advocacy, (April 24, 2013, 17:48 GMT), <http://advocacy.globalvoicesonline.org/2013/04/21/freerod-preliminary-victory-twitter-parody-case/>.

ХАВСРАЛТ D:

Жишээ баримт 2: Шүүхэд зарлан дуудах - Ассошиэйтэд Прессийн бичлэгийг мөрдөн тагнах ажиллагаа

2013 оны тавдугаар сард АНУ-ын Хууль зүйн департаментаас Ассошиэйтэд Пресст (АП) ажилтнуудынх нь 2012 оноос хойших утасны ярианы бичлэгт хоёр сарын турш хугацаанд хайлт хийхийг мэдэгдсэн захидал ирүүлэв. Үүнд гурван өөр улсад ажиллаж буй АП-ийн 40 сурвалжлагч, редакторт холбогдох ойролцоогоор албаны болон хувийн 20 утасны дугаар хамрагдаж байв. Хууль зүйн департамент (ХЗД) АП-ийн нэг жилийн өмнө нийтэлж байсан террорист хуйвалдааны талаарх мэдээллийн эх сурвалжийг илрүүлэхийг оролдож байсныг тайлангуудаас харж болно.

ХЗД нь АП-д илгээсэн захидалдаа хайлт хийхийн тулд шүүхэд зарлан дуудах бичиг үйлдсэн тухай мэдэгдсэн байна (шүүхээс зөвшөөрөл авах шаардлагагүй захиргааны үйл явц). Харилцаа холбоо дамжуулагчид (түүний дотор Verizon Wireless) үйлчлүүлэгчиддээ хайлтын талаар мэдэгдэл өгөх эсэхийг магадлалгүйгээр ХЗД-д мэдээлэл гаргаж өгснийг Нью Йорк Таймс илрүүлсэн байна.⁷⁴

Ийм үйлдэл нь сэтгүүлчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд ноцтойгоор халдаад зогсохгүй хүний эрхийг хамгаалагчид, шүгэлдэгчид болон олон нийтэд айдас төрүүлнэ. Мэдээлэл цуглуулах ажиллагааг өргөн хүрээнд хамруулах нь сэтгүүлчдийн зохих ёсны ажиллагаа явуулах эрхийг зөрчдөг. Учир нь тэдний хувийн нууцад хяналтын буюу хязгаарлалтын замаар хөндлөнгөөс оролцсон.

АНУ-ын засгийн газар нь холбооны хууль тогтоомжоор шүүхэд зарлан дуудах аргаар агуулгын бус хайлт хийхийг зөвшөөрөхийг шаардсан. Энэ хэрэг хэрэглэгчийн утасны дугаар, хэрэглэгч хэн рүү ярьсан, ярианы үргэлжлэх хугацаа, яриа хийсэн байрлал зэрэгт хайлт хийснээр маш их зүйлийг илрүүлж болдог гэдгийг харуулж байна. Уг явдал хэрэглэгчийн тодорхойлолт, харилцаа холбоо болон байрлалыг ялгаж салгах боломжтой тохиолдолд л шүүхээс өгсөн зөвшөөрлийг ашиглах явдлыг АНУ-ын холбооны хууль тогтоомжоор баталгаажуулан, нэмэлт өөрчлөлт оруулахыг уриалж байна.

⁷⁴ [74] Charlie Savage and Scott Shane, *Justice Dept. Defends Seizure of Phone Records*, *New York Times*, May 13, 2013, available at <http://www.nytimes.com/2013/05/15/us/politics/attorney-general-defends-seizure-of-journalists-phone-record-s.html?pagewanted=1&r=2&hp>.

Сургамж

АНУ-ын Ерөнхий прокурорын газар

- Ерөнхий прокурор нь шударга, эрх бүхий, хараат бус шүүх эрх мэдлийн байгууллагаас хайлт хийх зөвшөөрөл авах ёстой байв. (эрх бүхий шүүх эрх мэдлийн байгууллага)
- Энэхүү хүсэлтийг цаг хугацаа, хамрах хүрээгээр хязгаарлах шаардлагатай байсан. Гурван өөр улсаас 40 гаруй хувь хүмүүсийг хамарсан 20 утасны дугаарын дуудлагын бичлэгийг хоёр сарын турш мөрдөнө гэдэг хэтэрхий өргөн хүрээтэй хайлт болж байна. (дүйцэхүйц байх, нийцэхүйц байх, шаардлагатай байх)
- Утасны дугаарт хайлт хийх явдлыг шүүхийн нэг л тогтоолоор хязгаарлах нь зүйтэй.
- Хайлт хийх тухай хүсэлтэд бусад бага төвөг учруулах аргыг шавхсан тухай, мөн түүнчлэн уг хүсэлт нь хууль ёсны зорилгод нийцсэн, хайгдаж буй мэдээлэл олддоно гэсэн магадлал өндөр, ийм төрлийн хайлт хийх нь мэдээллийг олоход зайлшгүй шаардлагатай байсан тухай тодорхой бичнэ.
- Засгийн газрын зүгээс АП (болон бусад өртсөн хэрэглэгч)-д бүртгэлийг аль болох түргэн хугацаанд нэвтрэх тухайгаа мэдэгдвэл зохино. (мэдэгдэлд хамаарахгүй асуудлын талаарх хэсэгт дурдсан аливаа эрсдлийн дараа зогсоох буюу хүчингүй болгох).

Холбооны дамжуулагчид (түүний дотор Verizon Wireless компани)

- Холбооны дамжуулагчид хэт өргөн хүрээг хамарсан хайлт хийх хүсэлтээс татгалзах шаардлагатай байсан. Мөн үүнийг аль болох нарийвчлан тайлбарлах ёстой байсан.
- Холбоог дамжуулагчдад хориглоогүй тохиолдолд, үйлчлүүлэгчдэдээ шуурхай мэдэгдэх ёстой. Засгийн газар нь Ассошиэйтэд Пресст мэдэгдэх үүрэг хүлээсний зэрэгцээ Verizon Wireless компани дор хаяж сэтгүүлчдэд мэдэгдэж болох эсэхээ лавлах хэрэгтэй байсан.

Access нь дэлхийн өнцөг бүрт эрсдэлд өртсөн хэрэглэгчдийн цахим эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага юм.

Бид шинэлэг бодлого, хэрэглэгчийн оролцоо болон техникийн шууд тусламжийг хослуулан бүх нийтийн нээлттэй, аюулгүй харилцаа холбооны төлөө тэмцдэг.

Энэхүү удирдамжтай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл, тусалцаа авахыг хүсвэл info@accessnow.org цахим шуудангаар холбогдоно уу.